



Шинжээчийн тайлан

Байгууллагын нэр: Ач Анагаах ухааны их сургууль

Хөтөлбөрийн нэр: Анагаах Ухаан

Индекс: D091201

Шинжээчийн баг:

Ахлагч: Д.Мягмарцэрэн

Гишүүд: Т.Алтанцэцэг

Д.Баярмаа

Он сар өдөр: 2022.06.07

Агуулга

Товчилсон үгийн тайлбар	4
I.Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт	5
II.Сургалтын хөтөлбөрийн танилцуулга	6
III.Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт	7
Шалгуур 1: Хөтөлбөрийн төлөвлөлт	7
Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа	10
Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	14
Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	19
Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	22
Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа	28
Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт	32
IV.Уулзалтад оролцогчдын нэрс	35
I. Багш нарын нэрс	35
II. Оюутнуудын нэрс	36
III. Ажил олгогчдын нэрс.....	36
IV. Төгсөгчдийн нэрс	37
V.Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал	38
VI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр	
VII. Магадлан итгэмжлэхкомиссын шийдвэр	

Товчилсон үгийн тайлбар

“Ач” АУДС	“Ач” Анагаах ухааны дээд сургууль
“Ач” АУИС	“Ач” Анагаах ухааны их сургууль
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БСШУЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
МАУБХ	Монголын анагаах ухааны боловсролын холбоо
МБХА	Мониторинг, багш хөгжлийн алба
МИДСК	Монголын их дээд сургуулиудын консорциум
НЭМ	Нийгмийн эрүүл мэнд
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ОХУ	Оросын Холбооны Улс
ӨМӨЗО	Өвөр Монголын Өөртөө Засах Орон
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
УГНЭ	Улсын гуравдугаар нэгдсэн эмнэлэг
СААА	Санхүү, аж ахуйн алба
СБЗА	Сургалтын бодлого зохицуулалтын алба
ОА	Оюутны алба
ЗУЗ	Залуучуудын улаан загалмай
ХАОАТ	Хүн амын орлогын албан татвар
ХСҮТ	Хавдар судлалын үндэсний төв
ХӨСҮТ	Халдварт өвчин судлалын үндэсний төв
ЭХЭМҮТ	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв
ЭМАШТ	Эрүүл мэндийн анхан шатны тусламж
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭЕШ	Элсэлтийн ерөнхий шалгалт

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр /Монгол, Англи/	Ач анагаах ухааны их сургууль	
Сургалтын хөтөлбөрийн нэр	Анагаах ухаан	
Индекс	D091201	
Шинжээчид	<p>Ахлагч: Д.Мягмарцэрэн – АШУҮИС-ийн Анагаах ухааны сургуулийн өрхийн анагаах ухааны тэнхимийн эрхлэгч, доктор, дэд профессор</p> <p>Гишүүд: Т.Алтанцэцэг - Хүүхдийн төв сувилал Эмчилгээ эрхэлсэн орлогч захирал, доктор, профессор Д.Баярмаа -Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын Стратеги удирдлагын хэлтсийн Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн бодлого төлөвлөлт, нийгмийн баталгаа хариуцсан ахлах шинжээч</p>	
БМИҮЗ-ийн Мэргэжилтэн	Б.Мядагмаа - Магадлан итгэмжлэл хариуцсан ахлах шинжээч	
Төлөвлөгөө	Он сар өдөр	Хийгдсэн байх ажлууд /Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу бичнэ/
	2022.05.13	Ажлын албаны захирлын тушаалаар томилогдсон. № А/113
	2022.05.12	Ажлын албаны захиралтай гэрээ байгуулсан
	2022.05.30	Урьдчилсан үнэлгээний тайланг ажлын албаны мэргэжилтэнд хүлээлгэн өгсөн.
	2022.06.07-08	Сургууль дээр 2 өдөр хуваарийн ажилласан.
		Сургуулийн бэлтгэсэн илрэл нотолгоотой танилцсан.
		Сургуулийн анги, танхим, номын сан, лабораторитай танилцсан
2022.06.20	Сургуулийн багш, оюутан нартай уулзалт хийсэн. /танхимаар/	
	Төгсөгчид, ажил олгогч нартай уулзалт хийсэн. /онлайнаар/	
2022.06.20	Шинжээчийн багийн тайланг ажлын албанд хүлээлгэн өгсөн.	
Шалгуур шаардлага /журам/	БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 08 тоот тогтоолын гуравдугаар хавсралт. Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн нийтлэг шалгуур, шаардлага	

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

Ач анагаах ухааны их сургууль 1998 онд байгуулагдсан. Тус сургууль 2005 онд 5 жилээр, 2011 онд 10 жилээр тус тус магадлан итгэмжлэгдсэн. 2021 онд магадлан итгэмжлүүлэхээр хүсэлтээ өгөн ажиллаж байгаа. Дараах мэргэжлүүдээр бакалаврын хөтөлбөрөөр сургалт явуулж байна. Үүнд: Анагаах ухаан, Уламжлалт анагаах ухаан, Нүүр ам судлал, Нийгмийн эрүүл мэнд судлаач, Сувилагч

“Анагаах ухаан” хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгж:

1. Сургалтын Бодлого Зохицуулалтын Алба,
2. Анагаах ухааны сургууль,
 - ✓ Ерөнхий эрдмийн тэнхим
 - ✓ Морфологийн тэнхим
 - ✓ Физиологи, молекул, биологийн тэнхим
 - ✓ Бичил амь, халдварт өвчин судлалын тэнхим
 - ✓ Эмгэг судлалын тэнхим
 - ✓ Сувилахуйн тэнхим
 - ✓ Дотор, мэдрэлийн өвчин судлалын тэнхим
 - ✓ Мэс засал, гэмтлийн өвчин судлалын тэнхим
 - ✓ Өрхийн анагаах, эм судлалын тэнхим
 - ✓ Нийгмийн эрүүл мэндийн тэнхим
 - ✓ Хүүхдийн өвчин судлалын тэнхим
 - ✓ Эх барих, эмэгтэйчүүдийн өвчин судлалын тэнхим
 - ✓ Нүдний өвчин судлалын тэнхим
 - ✓ Чих хамар хоолойн өвчин судлалын тэнхим

“Анагаах ухаан” хөтөлбөрийг магадлан итгэмжлүүлэхэд ажиллах өөрийн үнэлгээний баг томилсон захирлын тушаал: 2020.10.14 оны А/28 тоот тушаалаар ажлын хэсэг байгуулагдан ажиллаж БМИҮЗ-д өргөдөл гаргаж, 2021 оны 1 сарын 26-ны № 04/2021 тоот гэрээ байгуулагдан, 2022 оны 6 сард “Анагаах ухаан” хөтөлбөрийн магадлан итгэмжлүүлэх өөрийн үнэлгээний тайланг БМИҮЗ-д хүргүүлж 2022.6.7, 8-ны өдрүүдэд “Ач” АУИС-д хөндлөнгийн үнэлгээ хийх шинжээчийн баг томилогдон ажилласан.

1998 онд анхны элсэлтээ авч, 2004 онд анхны төгсөлтөөр 38 төгсөгчийг төгсгөсөн байна.

2022 оны байдлаар нийт 18 удаагийн төгсөлтөөр 2189 “Хүний их эмч” бэлтгэгдсэн нь нийт төгсөгчдийн 63%-ыг эзэлж байна. “Ач” АУИС-ийг төгссөн “Хүний их эмч” мэргэжлээр 2020-2021 оны хичээлийн жилд суралцан төгссөн мэргэжилтэнүүдийн 90,8% мэргэжлээрээ ажиллаж байна.

2022 оны байдлаар Анагаах ухаан бакалаврын хөтөлбөрөөр нийт 6 дамжаанд 911 оюутан суралцаж байгаа бөгөөд нийт оюутнуудын 57%-ыг эзэлж байна.

2022 оны байдлаар “Анагаах ухаан” хөтөлбөр хэрэгжүүлэгч нийт 61 багшаас:

Доктор 25 буюу 41%

- i. ШУ-ны доктор 6,
- ii. АУ-ны доктор 15

Магистр 36 багш

46 хүний их эмч мэргэжилтэй

15 Багш, боловсрол судлал бусад мэргэжилтэй багш нар

Хичээлийн 4 байртай

“Ач” медикал интернэшнл нэгдсэн эмнэлэгтэй.

III. Шинжээчийнүнэнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Илрэл нотолгоо:

Ач Анагаах Ухааны их сургууль нь БСШУЯ-ны сайдын 1998 оны 202 тоот тушаалаар 1998 оны 09 сарын 01-ний өдрөөс эхлэн хүний их эмч бэлтгэх сургалтын үйл ажиллагааг эхлүүлэн “Анагаах Ухаан” бакалаврын хөтөлбөрөөр хүний их эмчид тавигдах нийтлэг шаардлагад нийцсэн хүний нөөцийг бэлтгэн гаргахад анхаарч сургалтын хөтөлбөрөө өнөөгийн эрүүл мэндийн салбарын эрэлт хэрэгцээ, төр, захиргааны байгууллагуудаас гаргасан хууль дүрэм, эрх зүйтэй уялдуулан шинэчлэн боловсруулж ирсэн байна. Сургалтын хөтөлбөр нь байгаль, хүмүүнлэгийн ухааны хичээлүүдээс бүрдсэн ерөнхий суурь, мэргэжлийн суурь болон эрүүл эмгэгийн үеийн биемахбодын бүтэц, үйлийг судлах анагаахын ерөнхий суурь хичээлүүд, эрхтэн тогтолцоо бүрийн эмгэг, тэдгээрийн эмгэг жам, шалтгаан эмнэлзүй, оношилгоо, эмчилгээний талаар судлан үзэх мэргэшүүлэх хичээлүүдээс бүрдсэн байна. Сургалтын хөтөлбөрүүдийг төрийн захиргааны төв байгууллагуудаас гаргасан хууль эрх зүйн баримт бичгүүдэд тулгуурлан тэдгээрт зохицуулан шинэчилж, өөрчилж ирсэн байна. Мөн салбарын хөгжлийн ирээдүйн төлөв, эрэлт хэрэгцээнд нийцүүлэн гадаад дотоодын ижил төстэй хөтөлбөрүүдтэй харьцуулан дүн шинжилгээ, бенчмарк хийж өөрийн хөтөлбөрийг дүйцүүлэн дүгнэлт хийж хэрэгжүүлж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Уламжлалт курацийн системээр сургалтаа явуулдаг
- Гадаадын болон дотоодын ижил төстэй сургуулиудын хөтөлбөртэй харьцуулж дүн шинжилгээ хийсэн байна.
- Хөтөлбөрөөр суралцагсдад зориулсан сургалтын бааз эмнэлгийг барьж сургалтанд ашиглаж байна.
- Түүхэн 20 жилийн хөгжлийг хадгалж ирсэн уламжлалтай
- Мэргэжлийн багш нар тус сургуульдаа 9-17 жил тогтвор суурьшилтай ажиллаж тодорхой туршлага хуримтлуулсан байна.

Анхаарах асуудал:

- Хэрэгжиж байгаа хөтөлбөрт ерөнхий суурь 30 хувь байхаас 15%, мэргэжлийн суурь 25 хувь байхаас 31%, мэргэшүүлэх хичээлийн эзлэх хувь 40% байхаас 55 хувь байна. Цаашид сургалтын хөтөлбөрыг боловсруулахдаа А/174 тоот тушаалыг баримтлан хичээл хувиарлалтыг анхаарч боловсруулах шаардлагатай
- **Зөвлөмж:**

- Цаашид хөтөлбөрийг боловсронгуй болгох, улмаар анагаах ухааны боловсрол судлалыг хөгжүүлж багш нарын хөтөлбөр боловсруулах, үнэлгээ хийх, оюутныг дүгнэх, сургалтын арга зүйг боловсруулахад идэвхи санаачилгатай, тэгш оролцоог хангаж ажиллах шаардлагатай.
- Хөтөлбөрийг боловсруулах тэнхим, багш нь хичээл хоорондын уялдаа, ялангуяа хичээл цагийн нягтрал, харьцааг (оюутан өдөрт хэдэн цагийн дадлага лекц семинарын хичээлд оролцох) жигд боловсруулж сургалтыг төлөвлөж ажиллах хэрэгтэй байна.

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Илрэл нотолгоо:

Хөтөлбөрийн зорилгыг “Хүн амыг эрүүлжүүлэх, өвчин эмгэгээс сэргийлэх, НЭМ-н сургалт явуулах чадвартай зонхилон тохиолддог өвчнийг оношлох, эмчлэх арга барилыг зохих түвшинд эзэмшсэн эмчийн ёс зүй, төрийн хуулийг чандлан сахидаг, ЭМАШТ-н хүрээнд ажиллах чадвартай хүний их эмч бэлтгэхэд оршино” гэж тодорхойлсон нь мэргэжилтэн бэлтгэх мэргэжилтний загвар, мөн төгсөн гарсан их эмчийн ажлын байранд тавигдах шаардлагад нийцсэн байна. Тухайлбал:

1. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх
2. Эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх
3. Яаралтай тусламж үйлчилгээ үзүүлэх
4. Эрдэм шинжилгээний ажил эрхлэх, оролцох

Хөтөлбөрийн зорилго харьцангуй тогтвортой, өөрийн нөхцөл байдалдаа тохируулан Мастер төлөвлөгөөг боловсруулан сургуулийн эрхэм зорилго, алсын хараатай уялдуулан ажиллаж байна. Сургуулийн эрхэм зорилгоо хэрэгжүүлэх үүднээс жил бүр шинэ зорилтуудыг дэвшүүлэн сургалтын хөтөлбөрөө боловсронгуй болгоход чиглүүлдэг байна. Төгсөгчдийн Холбоог байгуулан төгсөгчидтэй эргэх холбоотой ажиллан жил бүр санал асуулга авч суралцах үеийн хөтөлбөрийн хэрэгцээ нь ажлын байран дээр хэрхэн нийцэж байгаад дүн шинжилгээ хийж сургалтын хөтөлбөрийн МОД-г зөв гаргаж хөтөлбөрийн зорилгыг уялдуулан бүтцийг оновчтой тодорхойлж харуулсан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Төгсөгчдийн холбоо байгуулсан.
- Сургалтын бааз эмнэлэг түшиглэн төрийн болон хувийн эмнэлэгүүд, нөхөрлөл хэлбэрээр ажиллаж буй өрхийн эмнэлгүүдтэй гэрээ байгуулж тогтвортой ажиллах нөхцөл бүрдүүлж, сургалтыг зохион байгуулж байна.
- Төгсөгчид ажлын байрны хангалт сайн, нийт төгсөгчдийн 72% нь ажлын байраар хангагдан ажиллаж байна.
- Төгсөгчдийг авч ажиллуулах эрүүл мэндийн байгууллагын сэтгэл ханамж сайн.

Анхаарах асуудал:

- Сургалтын хөтөлбөрт Ерөнхий суурь 16 хичээл 28 багц цаг, мэргэжлийн суурь 23 хичээлийн 59 багц цаг, мэргэшүүлэх 40 хичээлээр 105 багц цаг (нийт 79 хичээл 192 багц цаг) суралцаж байгааг анхаарч дүн шинжилгээ хийж нотлох шаардлагатай байна. Сургалтын онцлог ч байх талтай юм.

Зөвлөмж:

- Тэнхим бүр тухайн хичээлийн жилд сургуулийн эрхэм зорилго, зорилготой уялдуулан тэнхимийн зорилгыг тодорхойлж хүрэх үр дүнг хөтөлбөрийн агуулгад тусган цогц чадамжийг боловсронгуй болгож боловсруулж ажиллах

1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

Хөтөлбөрийн зорилго, бодлого, төлөвлөлт нь мэргэжлийн стандарт, мэргэжилтний загвар, ажлын байрны тодорхойлолтод нийцсэн, сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгоход багш, оюутан, ажил олгогч, тэдний саналыг тусгадаг нь ажил олгогч, төгсөгчидтэй хийсэн ярилцлагаар нотлогдож байна. Хөтөлбөрийн төлөвлөлтийг хийхдээ Ач АУИС-ийн 20 жилийн туршлага, боловсролын хууль эрх зүйн баримтуудыг мөрдлөг болгон тэдгээрийг мэргэжлийн стандарт, мэргэжилтний загвар, ажлын байрны тодорхойлолт, төгсөгчдөд тавих нийтлэг шаардлага уялдуулан хурлын протокол тэмдэглэл, санал асуулга, дүгнэлтээр нотолгоожуулан мэдээллүүдийг эмх цэгцтэйгээр бүрдүүлсэн байна.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан**Онцлог зүйл/Туршлага:**

- Хамтын ажиллагааны гэрээтэй эмнэлгүүдтэй гэрээний дагуу дадлага сургалтыг зохион байгуулж, оюутан мэргэжлээ сонгох боломжийг бүрдүүлсэн байна.
- Мэргэжлийн болон мэргэшүүлэх хичээл заадаг багш нар тогтвор суурьшилтай ажиллаж байна.
- Сургалтыг эмнэлэгт суурилсан, дадлагажих нөхцөл боломжоор ханган сургалтын бааз эмнэлэг дээр явуулж байна.

Анхаарах асуудал:

- Сургалтыг явуулах хэлбэрүүдийг чадамжид суурилсан, харилцаанд суурилсан хэлбэрээр зохион байгуулдаг гэж тайлагнасан хэдий ч, хэрхэн яаж, ямар арга зүйгээр явуулах талаар тодорхой оновчтой тусгах шаардлагатай байна.

Шаардлага:

- Тухайн хичээлийн төгсгөлд оюутанг хэрхэн, яаж үнэлэх үнэлгээний аргачлал тодорхой бус, багшийн удирдлаган дор хийх үйлдэл хэмжигдэхүүн ойлгомжгүй юуг сонссон, харсан, хийсэн, чадсан гэдэг дээр анхаарч үнэлгээг оновчтой болгож хөтөлбөрт тусгаж ажиллах

Зөвлөмж:

- Гардан үйлдэл хийх боломжгүй нөхцөлд багш нар эмнэл зүйн сургалтыг тохиолдолд суурилсан тухайлбал: /OCSE, OSPE/ хэлбэрээр зохион байгуулах, шалгах хуудсыг хийсэн, хийгээгүй гэсэн байдлаар өөрөөр хэлбэл /yes.no/ гэсэн оноогоор дүгнэж оюутан бүрийг жигд оролцуулан асуудал шийдэх, шийдвэр гаргах түвшинд зохион байгуулах

1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Илрэл нотолгоо

Хичээлийн индекс, хичээлийн суралцахуйн үр дүнгийн матриц

“Ач” АУИС-ийн эрхэм зорилгыг “Хүн амд чанартай, үр дүнтэй тусламж, үйлчилгээ үзүүлэхүйц мэдлэг, дадлага, хандлага бүхий, бие даан хөгжих чадвартай, бүтээлч эмнэлгийн мэргэжилтэн бэлтгэж, хүний хөгжилд бодит хувь нэмэр оруулах сургалт-эрдэм шинжилгээ-үйлчилгээний тэргүүлэх байгууллага байхад оршино” хэмээн тодорхойлж, эрхэм зорилгыг хангахуйц мэргэжилтэн бэлтгэх сургалтын хөтөлбөр, хичээлийн агуулга, сурах, сургах арга зүй, үнэлгээний арга зүй, орчинд чиглэсэн олон талын үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаа нь сайшаах ахиц дэвшил гэж үзэж байна. Анагаах ухаан 091201 мэргэжлийн индексийн дагуу 192 кредит судлан төгсөж байна. Анагаах ухаан хөтөлбөрийн матрицыг мэдлэг олгох-13, үзлэг хийх, анхан шатны маягт бөглөх, лабораторийн шинжилгээнд дүгнэлт хийх, лавлагаа шатлалын эмнэлэгт илгээх, багаж тоног төхөөрөмж ашиглах, амин үзүүлэлт үзэх, анхны тусламж үзүүлэх, хэвийн төрлөг удирдах зэрэг 19 ур чадвар, бусдыг хүндэтгэх, үйлчлүүлэгчийн нууцыг хадгалах, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрмийг сахих, багаар ажиллах 4 хандлагаар тус тус тодорхойлжээ.

Удирдлагын мэдээллийн систем дэх сонголтууд

“Ач” АУИС –ийн нэвтрүүлж буй Cloud University систем Админы программ, Мониторын программ, Албадын программ, Багшийн программ, Оюутны программ дэд программуудтай байна.

Админ программ: Сургуулийн үндсэн мэдээллийн бүртгэл, мэргэжлийн салбар, тэнхимүүдийн бүртгэл, ажлын байр, албан тушаалуудын бүртгэл, албад, тэдгээрийн ажилтнуудын бүртгэл, системд хандах эрхийн зохицуулалт, төгсөлтийн шалгалт, төгсөгчдийн хавсралтын тохиргоог оруулжээ.

Албадын програм: Сургалтын бодлого зохицуулалтын алба, Төгсөлтийн дараах сургалт-судалгааны алба, Оюутны алба, Мониторинг, хүний нөөцийн алба, Санхүү, аж ахуйн албадын арга зүйч, мэргэжилтнүүдэд зориулсан байна.

Багшийн програм: Хичээлийн стандарт, үндсэн болон нэмэлт бичгийн жагсаалт, лекц, семинар, лаборатори, бие даалтын сэдвүүд, Хичээлийн нэмэлт материалуудыг видео болон бусад файлууд байршуулах, СБЗА-аас оруулсан хичээлийн хуваарийг харах, хэвлэх боломжтой байна.

Оюутны программ: Оюутны хичээл сонголт хийх, оюутны болон дүнгийн тодорхойлолт, хичээлийн хувиараа хянах, багшийн болон хичээлийн санал асуулгад хамрагдах, олон нийттэй харилцах зар мэдээ хүлээн авах, багш болон сургалтын албаны мэргэжилтэнтэй цахим хэлбэрээр холбогдох боломжтой.

Сургалтын нэгдсэн төлөвлөгөөнд хийсэн шинжилгээ

Сургалтын төлөвлөгөөнд үе шаттай дүн шинжилгээ хийж, сайжруулах ажил зохион байгуулдаг байна. Тухайлбал: 2009, 2013, 2014 онуудад “Ач” АУИС-ийн захирлын

тушаалаар “Анагаах ухаан” сургалтын хөтөлбөрийг шинэчлэх ажлыг зохион байгуулжээ. 2014 онд шинэчилсэн сургалтын хөтөлбөр нь ерөнхий суурь **28**, мэргэжлийн суурь **59**, мэргэшүүлэх **105**, нийт 192 кредитийн агуулгын багтаамжтай судлахаар боловсруулагдсан байна.

Дадлагын талаар хамтран ажиллах гэрээ, санамж бичиг, удирдамж, журам, ажлын тайлан, анализ

Тус сургууль нь УГНЭ, Сэтгэцийн Эрүүл Мэндийн Үндэсний Төв, Орбита нүдний эмнэлэг, Гэмтэл Согог Судлалын Үндэсний Төв, Сонгинохайрхан дүүргийн нэгдсэн эмнэлэг, Амгалан, Хүрээ амаржих газрууд, Архангай, Хөвсгөл, Дархан-Уул, Орхон аймгийн нэгдсэн эмнэлгүүдтэй хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна. Гэрээт байгууллагын эмч, сувилагч нарыг сургалтанд хамруулах, эрдэм судлалын ажлыг нь удирдах, бааз эмнэлгийн хичээлийн өрөөг тохижуулах зэргээр хамтын ажиллагаа явуулдаг байна.

Хичээл хоорондын залгамж холбоог харуулсан график /хөтөлбөрийн мод/

Сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээл хоорондын залгамж холбоог мэргэжлийн багш нар болон хөтөлбөрийн хороогоор хэлэлцүүлж, агуулгын хувьд уялдуулах тал дээр түлхүү анхаарч хөтөлбөрийн мод боловсруулжээ. Хичээлийн хөтөлбөр, стандартад тухайн хичээлийг судлахын өмнө заавал судалсан, амжилттай дүгнэгдсэн байх хичээлийн нэр, код, кредит цагийг зааж өгсөн байна.

Суралцагчийн цагийн ачаалал тооцсон судалгаа

Хичээлийн жилийн нэг улирал 16 долоо хоногтой ба 3 кредит бүхий хичээл 144 цаг, 2 кредит хичээлийн хувьд 96 цаг сургалтын үйл ажиллагаанд зарцуулахаар 192 кредитийг зохицуулсан бөгөөд 5 дугаар дамжаанд бусад дамжаанаас ачаалал илүү байна. Сургалтын төлөвлөгөөнд тусгагдснаар нийт 192 багц цагийн 14,3 хувь нь лекц, 5,7 хувь нь семинар, 32,3 хувь нь дадлага, 47,7 хувь нь бие даалтын цаг байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.

Онцлог зүйл/Туршлага

- Cloud University систем энгийн бүтэцтэй, интернетэд холбогдсон, дурын төхөөрөмжөөс хандах боломжтой. Суралцагчийн элсэлтээс эхлэн төгсөх хүртэлх сурлагын үзүүлэлт, мэдээллийг цогц байдлаар харах, дипломын хавсралтыг хэвлэх үйл ажиллагаа сургалтын үйл ажиллагаанд хэвшсэн.
- Зуны үйлдвэрлэлийн дадлага хийх бааз эмнэлгүүдтэй гэрээ хийсэн, эмнэлгүүдийн удирдлагууд “Ач” АУИС-тай хамтран ажиллахдаа сэтгэл хангалуун байдаг.

Анхаарах асуудал:

- Өөрийн үнэлгээний тайланд кредит системийн талаар онолын мэдээлэл илүүтэй орж, сургуулийн зүгээс хийсэн суралцагчийн цагийн ачаалал тооцсон судалгаа, дүн тодорхой тусгагдсангүй.
- Багш нарын Cloud University систем ашиглах чадварыг дээшлүүлэх

Зөвлөмж:

- Анагаах ухаан сургалтын хөтөлбөрийн ерөнхий суурь 28, мэргэжлийн суурь 59, мэргэшүүлэх 105 зохистой харьцаанд дүн шижилгээ хийж өөрийн сургалтын онцлогийг харуулах нь зүйтэй.

- Сургалтын нэгдсэн төлөвлөгөөнд дүн шинжилгээ, багш, суралцагчдын ачаалал тооцсон судалгааг тогтмол хийх

2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Илрэл нотолгоо:

Сургалтын арга зүйг хэрэгжүүлэх загвар, заавар, зөвлөмж

“Ач” АУИС-ийн захирлын 2015 оны 6 дугаар сарын 25-ны 09 тоот хурлын шийдвэрийг үндэслэн Сургалтын технологи, чанарын хяналтын журам батлагдсан байна. Оюутан төвтэй, тэдний оролцоог дэмжсэн сургалтын аргыг түлхүү ашигладаг байна. Багш онолын мэдлэгийг лекц, семинар, бие даалтын хичээлээр олгох бөгөөд оюутан унших, тэмдэглэл хөтлөх, судлах, дэвшилтэт технологи ашиглан мэдлэгээ бататгах, дадлагажих замаар сургалт явуулдаг байна. Багш бүр хичээлийнхээ сургалтын арга зүйд шинэчлэл хийж, асуудалд суурилсан эмнэл зүйн тохиолдол шийдвэрлэх, дүрд тоглох, мэтгэлцэх, илтгэл тавих, үйлчлүүлэгчийн орны дэргэд сургалт явуулах зэрэг аргуудыг нэвтрүүлж байна.

Сургалтын арга зүйд хийсэн анализ судалгааны баримт материал

Ерөнхий суурь хичээлээс бие даалт, хэсэгчилсэн хайгуул хийхэд суурилсан сургалт 36,4%, жижиг бүлэгт суурилсан сургалт 27%-ийг эзэлж байна. Мэргэжлийн суурь хичээлээс асуудалд суурилсан сургалт 55,6%, бие даалт 44,4%, жижиг бүлгийн сургалт 38,9% тус тус, мэргэшүүлэх хичээлийн 77,3% асуудалд суурилсан, үйлчлүүлэгчийн орны дэргэд 18,2%, жижиг бүлгийн хичээл 22,7% эзэлж байгаа судалгааны дүн байна. Хүний их эмчийн ангийн I-VI дамжааны нийт 824 оюутнуудын дунд 17 асуулт бүхий асуумжаар судалгаа явуулахад судалгаанд хамрагдагсдын 75% нь хичээл явуулж буй арга, хэлбэр тохиромжтой, өгөөжтэй, ойлгомжтой байдаг болохыг тэмдэглэжээ.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага

- Ерөнхий суурь, мэргэжлийн суурь, мэргэшүүлэх хичээлүүдийг удирдаж буй сургалтын аргуудад дүн шинжилгээ хийж, судлагаатай ажиллаж байна.
- Сургалт явуулах олон аргыг ашиглаж байна.
- Багш нар заах арга, сургалтын арга зүйгээ сайжруулахад анхаарч ажиллаж байна.

Анхаарах асуудал:

- Судалгааны дүнгээс харахад бие даалтын хичээлийн эзлэх хувь өндөр байгаа тул бие даалтын хичээл явуулах, суралцагчийн гүйцэтгэх даалгавар, үнэлэх шалгуур тодорхой байхыг журамлах
- Дадлага хийсэн байгууллагаас суралцагчдын мэдлэг, чадвар, хандлагын талаар дүгнэлт хийж болохуйц асуулт бүхий хуудсаар санал авч, цаашид сургалтын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор тусгаж ажиллах

Зөвлөмж:

- Хичээлийн сэдэв тус бүр, тухайн сэдвийн агуулгат тохирсон сургалтын арга, хэлбэрийг сонгох тал дээр анхаарч, хичээлийн хөтөлбөрт тодорхой тусгах
- Сургалтын хөтөлбөрийн агуулгын хүрээнд бие даалтаар судлах хичээлийн сэдвүүдийг тодорхойлж, оюутны зайлшгүй унших, ашиглах мэдээлэлийн эх сурвалжийн жагсаалт, эзэмших ур чадвар, гүйцэтгэх үйлдэл, гүйцэтгэлийг тооцох хэлбэр хугацааг тодорхойлох

2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

Сургалтанд ашиглаж буй үнэлгээний аргазүйн судалгаа /Блут таксономи, Рубрик арга/

Тайланд сургалтад ашиглаж буй үнэлгээний аргазүйн судалгаа хийсэн мэдээлэл ороогүй болно. Сургалтад мэдлэг үнэлэх: аман шалгалт, бичгийн шалгалт, эмнэлзүйн тохиолдолд суурилсан сорил, ур чадвар, хандлага үнэлэх: OSCE, OSPE, гардан үйлдлийн шалгалт, өртөөчилсэн шалгалт, цогц чадамж үнэлэх: эмнэл зүйн дасгал үнэлгээ, 360 хэмийн үнэлгээг тус тус хэрэглэдэг байна.

Хичээл нэг бүрийн үнэлгээнд хийсэн дүн шинжилгээ, анализ /шалгалтын хэлбэр, асуулт даалгавар, сорилын санд хийсэн шинжилгээ/

Мэргэшүүлэх хичээл тус бүрийн төгсгөлд аман шалгалтын үнэлгээний хэлбэрийг 100% ашигладаг бол гардан үйлдлийн шалгалтыг 21,8%, эмнэлзүйн бодлого 28,1% ашиглаж байгаа бөгөөд сорилын сан 3344 байна. Явцын болон Шалгалтын дүнгийн харьцаа 50:50. Анагаахын салбарын шалгалтын найдвартай байдал 2 вариантын хувьд онцын ялгаагүй KR 0.94-0.96, шалгуулагчийн гүйцэтгэлийн дээд оноо 147, доод оноо 41 байсан. 23 хичээлийн 300 сорилын 5% нь хэт хүнд, 33% хүнд, 10% тохиромжтой, 48% хөнгөн, 4% хэт хөнгөн байсныг тэмдэглэсэн байна. Халдварт өвчин, эм судлал, зүрх судас, дотоод шүүрэл, ЧХХ, хоол боловсруулах эрхтэн судлал, гэмтэл судлал, яаралтай тусламжийн хичээлийн сорилууд хэт хүнд, мэс засал, эх барих эмэгтэйчүүд, цусны эмгэг судлал, хэт хөнгөн үнэлэгджээ.

Явцын болон төгсөлтийн шалгалтын журам

Ач АУИС-ийн захирлын 2016 оны 08 сарын 31 өдрийн А/038 тоот тушаалаар батлагдсан “Оюутны үнэлгээний журам”-ыг мөрдөж байна. Энэхүү журамд оюутныг үнэлэх аргачлал, үнэлгээний голч дүн, хичээл нөхөн суралцах, шалгалт өгөх, шалгалт дахин өгөх талаар заасан байна. Төгсөлтийн шалгалтыг “Ач” АУИС-ийн захирлын 2015 оны А/44 тоот тушаалаар батлагдсан “Төгсөлтийн шалгалтын журам”-ын дагуу зохион байгуулдаг. Төгсөлтийн шалгалт нь онол болон дадлага хэлбэрээр зохион байгуулдаг. Онолын шалгалт нь сургалтын төлөвлөгөөн дэх мэргэжлийн хичээлүүдийн агуулгын багтаамжтай нэг сонголттой сорил 50, олон сонголттой сорил 50, уялдуулан сонгох 25, шалтгаан хамаарлын 25 сорил бүхий 150 сорилыг 150 минутын хугацаанд бөглөдөг байна.

Дадлага шалгалт нь мэс засал, дотрын өвчин судлал, эх барих эмэгтэйчүүд, хүүхдийн өвчин судлал 4 өртөөнд эмнэлзүйн тохиолдол, бодлого, гардан үйлдлийн даалгаврыг гүйцэтгэдэг байна. 1 оюутан 1 өртөөнд 8 минут бэлдэж, 8 минутанд даалгавар

гүйцэтгэнэ. Онол болон дадлага шалгалтын үнэлгээ нь 70%-С дээш үнэлэгдсэн тохиолдолд төгсөлтийн шалгалтыг амжилттай давсанд тооцогддог байна.

Суралцагчийн сурлагын амжилт, ахицын талаарх статистик мэдээлэл, боловсруулалт, дүгнэлт дүн /голч дүн, хичээлд унасан оюутны тоо, сурлагын амжилт, чанар гэх мэт/

Сургалтын бодлого зохицуулалтын алба суралцагчийн сурлагын амжилтанд дүн шинжилгээ хийж, голч дүнг гаргадаг байна. Анагаах ухаан хөтөлбөрөөр суралцагч оюутнуудын голч дүнгийн байдалд сүүлийн 5 жилийн байдлаар /2016-2021 оны хичээлийн жилүүдэд/ судалгаа хийхэд 1-р дамжаанд 2,8-с 3, 2-р дамжаа 2,7-3, 3-р дамжаа 2,7-3, 4-р дамжаа 3-3,2, 5-р дамжаа 3-3,2, 6-р дамжаа 3,1-3,1 болж өссөн дүн гарчээ.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Шалгалтын олон хэлбэрүүдийн сургалтанд ашиглахыг зорьж байна.

Анхаарах асуудал:

- Оюутны сурлагын амжилт, чанар, ахицын талаарх мэдээллийг тайланд сайтар тусгаж өгөх шаардлагатай.

Зөвлөмж:

- Оюутан төвтэй шалгалтын аргыг нэвтрүүлэх, үнэлгээний шалгуурыг тодорхой болгох
- Сургалтад мөрдөж буй журам, шалгуурууд нь 2015-2016 онд боловсруулагдсан байгааг цаг үе, дээд боловсролын шинэчлэлтэй холбогдуулан сайжруулан, шинэчлэх

2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Илрэл нотолгоо:

Хичээлийн байр, сургалтын анги танхим, лаборатори, урлан, бие даан болон багаар ажиллах орчны хүрэлцээ, хангамж

2022 оны 6 дугаар сарын 07-ноос 08-ны өдрүүдэд сургалт, судалгаа явуулах анги, танхим, лаборатори, багаж хэрэгсэл, багшийн өрөө, танхимын нөхцөл байдалтай танилцсан.

Хичээлийн нийт 6,295.8 м² талбай бүхий 4 объект байртай, хичээлийн нэгдүгээр байр 1600 м², хоёрдугаар байр 1800 м², гуравдугаар байр 1700 м², өргөтгөл байр нь 1051 м².

Хичээлийн байранд 822 хүний багтаамжтай лекцийн 8 танхим, дадлагын шаардлагатай тоног төхөөрөмж бүхий 697 хүний багтаамжтай 36 анги танхим, 2 номын сан, 10 лаборатори, багш ажилчдын байрлан ажиллах 18 танхим өрөөтэй, бие даасан 714 м² талбай бүхий

спорт заалтай, 467 хүний багтаамжтай оюутны дотуур байртай, 60 суудал бүхий 200 м2 талбайтай цайны газартай, 18 ширээ, 30 сандалтай нээлттэй мэдээллийн төвтэй.

2022 онд Ач АУИС-ийн сургалтын бааз эмнэлэг болох 120 ортой, 8200 м2 талбайтай “Ач интернэшнл медиал”-ийн барилгын ажил 100 хувийн гүйцэтгэлтэй, 15 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж, ашиглалтад оруулахад бэлэн болсон бөгөөд лаборатори, эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж, суурилуулалтын ажил хийгдэж байна. Лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээг амбулатори болон хэвтүүлэн эмчлэх хэлбэрээр үзүүлэх тус эмнэлэг нь ашиглалтад орсоноор 220 орон тоотой ажиллаж, 3.5 тэрбум төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл, 3.3 тэрбум төгрөгийн ХАОАТ, 3.3 тэрбум төгрөгийн ААНОАТ улсад төлөхөөр төлөвлөгдсөн. Эрүүл мэндийн сайдын 2022 оны 3 дугаар сарын 31-ний А/182 дугаар тушаалаар тус эмнэлэгт “нэгдсэн эмнэлгийн тусламж, үйлчилгээ”-ний чиглэлээр ЭХ-22/23/0002 дугаартай мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээг 2025 оны 3 дугаар сарын 31-ний өдөр хүртэл 3 жилийн хугацаагаар шинээр олгосон байна.

Ашиглалтын сэтгэл ханамжийн судалгааны үр дүн, хийсэн ажлын тайлан

Сургалтын орчны талаар жил бүр оюутнаас санал асуулга авдаг, тухайлбал 2018-2019 онд нийт 8, 2019-2020, 2020-2021 онд нийт 13 асуултаар санал асуулга авч, холбогдох арга хэмжээ авч ажилласан байна. 13-аас 10 асуултад 3-аас дээш оноог оюутнууд өгсөн, сургалтын орчин, мэргэжлийн анги, танхимын хүрэлцээ тааруу гэсэн үзүүлэлт гарсан.

2019-2020 оны Анагаах ухааны сургалтын хөтөлбөрийг төгсөгчдийн мөшгих судалгаанд нийт 230 төгсөгчийн 52.7% оролцсон бөгөөд анги, танхимын тоог нэмэх, оюутны дотуур байрны нөхцлийг бүх талаар сайжруулахад анхаарах, гадаад болон дотоод орчинг сайжруулах /сандал, агааржуулагч, гадаад үзэмж гэх мэт/ гэсэн санал өгсөн байна.

Сургуулийн өргөтгөлийн шинэ барилгыг ашиглалтад оруулж, сургалтын өрөөний хүрэлцээ, нормыг нэмэгдүүлэх арга хэмжээг сургуулийн зүгээс авсан байна.

Сургалтын тоног төхөөрөмж, мэдээллийн технологийн хэрэгсэл, цахим орчны ашиглалт, хүртээмж, сэтгэл ханамжийн судалгаа

Хичээлийн нэгдүгээр байрны уншлагын танхим 200 суудалтай, гуравдугаар байрны уншлагын танхим 100 суудалтай, оюутны байрны уншлагын танхим 20 суудалтай. Сургуулийн хэмжээнд интернэтэд холбогдсон компьютерийн тоо 171. Цахим сургалтын хяналт-шинжилгээний хуудсаар тайланг авдаг, е-хичээлийн сан, удирдлага мэдээллийн систем Cloud University, Google education apps (2013 оноос) ашигладаг. Оюутны байранд 24 цагийн тогтмол холболттой wifi интернэттэй.

Цахим сургалтын үйл ажиллагааг эрхлэх түр журам, 2021-2022 оны хичээлийн жилийн танхимын болон цахим сургалтын үйл ажиллагааг зохион байгуулахад мөрдөх журмыг захирлын тушаалаар, төгсөлтийн онолын шалгалтын түр журмыг Сургалтын бодлого зохицуулалтын албанаас баталж, цахим хэлбэрээр “Google form” ашиглан зохион байгуулсан.

Сургалттай холбоотой санал, гомдлыг оюутны албаны цахим хаяг, фэйсбүүк хуудсаар авч шийдвэрлэдэг. Цахим хичээлийн хөтөлбөрийн агуулга, арга зүй, багш, үнэлгээ, орчин, зохион байгуулалт чиглэлээр 20 асуумж бүхий судалгааг 5 мэргэжлээр суралцаж буй оюутнуудаас 2020 онд авахад “Сургалт үр дүнтэй сайн сургалт” гэдэгтэй 42% нь санал бүрэн нийлнэ, 25% нь ихэнхдээ санал нийлнэ, 9% нь дунд зэрэг нийлнэ, 24% нь огт санал нийлэхгүй, ихэнхдээ санал нийлэхгүй гэж хариулсан байна. Санал огт нийлэхгүй гэсний шалтгаанд 25 нь удирдлага, зохион байгуулалт, 24% нь багшийн заах арга зүй, 23% нь сургалтын орчин, 16 хувь нь хөтөлбөрийн агуулга гэж дурдсан бөгөөд эдгээр санал огт нийлэхгүй, ихэнхдээ нийлэхгүй гэсэн оюутнуудын 68% нь Анагаахын хөтөлбөрийн оюутнууд байсан.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Эрүүл мэндийн чиглэлээр сургалт эрхлэх зөвшөөрөл бүхий хувийн өмчийн их, дээд сургуулиудаас анх удаа их сургуулийн бааз эмнэлэгтэй болсон, “нэгдсэн эмнэлгийн эмнэлгийн тусламж, үйлчилгээ”-ний чиглэлээр мэргэжлийн үй ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Эрүүл мэндийн яамнаас 3 жилийн хугацаатай олгосон.
- Спорт заал, фитнес клубтэй, сургалтын байрны өргөтгөл шинээр ашиглалтад оруулсан.

Анхаарах асуудал:

- 5 давхар оюутны дотуур байрны 2 дугаар давхарт Нүүр ам судлалын сургуулийн анги, кабинет байрлаж байгааг анхаарч, дотуур байрны барилгыг зориулалтаар нь бүрэн хүчин чадлаар нь ашиглах.
- Оюутны дотуур байрны гал тогоо, ариун цэврийн өрөөний цэвэрлэгээ, эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах.
- Цайны газрын хоолны цэс, үнийг анхаарах (оюутнуудтай хийсэн уулзалтаар хоолны үнэ өндөр байна гэсэн).

Зөвлөмж:

- Эмнэл зүйн ур чадвар, гардан үйлдлийн кабинет/өрөөг нэмэгдүүлэх, манекан, муляж, хэрэглэгдэхүүний тоо, төрлийг нэмэгдүүлэх, шинэчлэх.
- Нэг багш, суралцагчид ногдох өрөө, танхимын талбайг нэмэгдүүлэх.
- Тоног төхөөрөмж, эд хогшлын худалдан авалтын жагсаалт, засварт зарцуулсан зардлыг тайланд тодорхой тусгаж хэвших.
- Цахим сургалтын агуулга, багшийн заах арга зүй, зохион байгуулалтыг сайжруулах.

3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Илрэл нотолгоо:

Сургалтын хэрэглэгдэхүүн, нөөцийн жагсаалт, хүртээмж, ашиглалт, сэтгэл ханамжийн судалгаа

2017 онд нийт 2841 хэрэглэгдэхүүн ашиглаж байсан бол 2022 онд 18 төрлийн нийт 5585 үзүүлэн таниулах материал, багаж тоног төхөөрөмж хэрэглэдэг болж нэмэгдсэн байна. Оюутнуудаас сургалтын чанарын сэтгэл ханамжийн судалгааг жил тутам авч хэвшсэн.

2016-2018 оны Анагаах ухааны сургалтын хөтөлбөрийг төгсөгчдийн мөшгих судалгаанд нийт 565 төгсөгчийн 60% оролцсон бөгөөд сургалтын хөтөлбөрт өгсөн сэтгэл ханамжийн хувьд дийлэнх төгсөгч сэтгэл ханамжтай, давуу талтай, багаар ажиллах, эрсдэл хүлээх, санаачлах, ур чадвар эзэмшилтэд сэтгэл ханамж маш их, харин компьютер, гадаад хэлний мэдлэгийн чадварын хувьд сэтгэл дундуур байгаагаа илэрхийлсэн. Анги, тоног төхөөрөмж, судалгааны чадавхи, багшийн чанар, хичээлийн тоог давуу гэж үнэлсэн бол сургалтын төлбөрийг боломжийн, оюутны ачааллыг дундаж, хөдөлмөрийн зах зээлд зохицох байдалд сул буюу эмнэлгийн орчинд дадлагажих нөхцөл сул гэсэн байна.

2019-2020 оны Анагаах ухааны сургалтын хөтөлбөрийн төгсөгчдийг мөшгих судалгаанд нийт 230 төгсөгчийн 52.7% оролцсон бөгөөд сургалтын хөтөлбөрийн давуу талыг сургуулийн нэр хүнд, багшийн мэдлэг, туршлага, харилцаа хандлага, сургалтын арга барил, технологи, харин сул талыг сургалтын тоног төхөөрөмж, тэтгэлэгт хамрагдах боломж гэж үнэлсэн.

Сургалтын ажлыг зохион байгуулах заавар, удирдамж, зөвлөмж

Сургалтын заавар, удирдамж, зөвлөмжийг “зөвлөх багш” нар хүргэдэг, оюутны алба хэвшүүлэх ажлыг гүйцэтгэдэг.

Е-контент түвшинд боловсруулсан сургалтын материал

Коронавируст халдварын нөхцөл байдлаас хамаарч, 2020 оны 1 дүгээр сарын 28-аас сургалтыг цахим хэлбэрээр зохион байгуулах шийдвэр гаргаж, хичээл бүрийг цахим хэлбэрт шилжүүлж боловсруулж, Classroom.google системд байршуулах, судлах ном, сурах бичгийг цахимаар хүргэх зохицуулалт хийсэн байна. Е хичээлийн санд 2020-2021 онд бакалаврын 5 хөтөлбөрт 1 дүгээр улиралд 161, 2 дугаар улиралд 172 цахим хичээлийг аудио тайлбартай оруулсан. Сургалтыг цахим сургалтын Google meet системээр онлайнаар шууд явуулж хэвшсэн. Цахим сургалтын нэгдсэн стандартыг Сургалтын бодлого зохицуулалтын албанаас гаргасан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Google цахим сургалтын системийг ашигладаг, албан ёсны цахим хаягаар тусгайлан эрх авсан.
- Сургуулийн хэмжээнд Cloud University ашигладаг.

Анхаарах асуудал:

- Өөрийн үнэлгээний тайланд дүрэм, журам, захирлын зөвлөлийн шийдвэр, тушаал, зааврыг вэб хуудаст байршуулдаг гэсэн ч сургуулийн вэб хуудаст байршуулаагүй, танилцах боломжгүй байгааг анхаарч, вэб хуудасны мэдээллийг монгол болон англи хэлээр байршуулах, тогтмол шинэчлэх.
- Цахим сургалтын агуулгын хүрээнд дадлага хичээлүүд явагдах боломжгүй, хангалттай түвшинд ур чадвар олгож чадахгүй байгааг анхаарч, зохицуулалт хийх.

Зөвлөмж:

- Сургалтыг цахимжуулах чиглэлээр хийгдсэн үйл ажиллагааг тайланд тодорхой тоо баримттай дурдах.
- Тоног төхөөрөмж болон хэрэглэгдэх материалын жагсаалт, шинэчлэлийн талаар тайланд тусгах.

3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

Илрэл нотолгоо:

Үндсэн сурах бичиг, гарын авлага, эрдэм шинжилгээний сэтгүүлийн жагсаалт, сэтгэл ханамжийн судалгаа.

Өөрийн үнэлгээний тайланд дурдсанаар номын сан нь орос, монгол, англи хэл дээрх 17852 ном, сурах бичигтэй. Номын санчтай 2022 оны 6 дугаар сарын 08-ны өдөр ярилцлага хийж, номын санд ашиглаж буй Lib4U програмтай танилцаж, номын сангийн уншигчийн эрх, номын фондын жагсаалтыг гаргуулж танилцахад:

- 1783 уншигч номын сангийн эрхтэй (оюутан, багш нар)
- 1182 төрлийн монгол номын жагсаалт
- 905 төрлийн орос номын жагсаалт
- 555 төрлийн англи номын жагсаалт

- 102 эрдмийн ажлын катологийн жагсаалт
- анагаах ухааны чиглэлээрх 105 монгол сэтгүүлийн жагсаалт
- анагаах ухааны чиглэлээрх 33 англи сэтгүүлийн жагсаалт
- 13 цагийн байдлаар үйлчилгээнд гарсан 178 ном, сэтгүүл, сурах бичгийн жагсаалтыг хэлээр ангилахад монгол – 171, орос – 6, англи - 1 байсан.

Мэргэжлийн ном, сурах бичгийн баяжилт, шинэчлэлтийн судалгаа

Номын сангийн баяжилт жил тутам хийдэг.

- 2022 онд нийт 4 удаагийн худалдан авалт, 3 удаагийн хандиваар 12 төрлийн 204 ширхэг 15 сая 150000 төгрөгийн үнэ бүхий монгол ном шинээр нэмсэний 189 нь анагаах ухаан, 15 нь соёл, шинжлэх ухаан, боловсролын чиглэлийн ном байна.
- 2021 онд нийт 6 удаагийн худалдан авалт, 12 удаагийн хандиваар 115 төрлийн 770 ширхэг 15 сая 690000 төгрөгийн үнэ бүхий монгол ном шинээр нэмсэний 584 нь анагаах ухаан, 20 нь социологи, статистик, хүн ам зүй, 15 нь түүх, 67 нь соёл, шинжлэх ухаан, боловсрол, 45 нь хэл шинжлэл, 15 нь уран зохиол, 1 нь лавлах хэвлэл, 3 нь бусад чиглэлээр байна.
- 2017 онд 9 удаагийн худалдан авалт, 3 удаагийн хандиваар 212 төрлийн 693 ширхэг 198 сая 105236 төгрөгийн 458 монгол, 235 англи ном шинээр нэмсэний 641 нь анагаах ухаан, 3 нь түүх, 22 нь соёл, шинжлэх ухаан, боловсрол, 24 нь хэл шинжлэлийн чиглэлээр байна.
- 2016 онд номын санд нэмэгдсэн материал байхгүй.

Цахим мэдээллийн сан, нээлттэй эх үүсвэрийн ашиглалтын судалгаа

Номын сангийн цогц програм хангамжтай – Lib4U. Номын сангийн Lib4U програмаар бүх номыг системд бүртгэж, баг кодтой болгож, 100 хувь электрон каталогтой болгосон, электрон катологоос түлхүүр үгээр оюутнууд хайж олж, ашиглах боломж бүрдүүлсэн. Zotero, Hinari программ мөн ашигладаг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Эрдмийн бүтээл цахимжуулж эхэлсэн.
- Мэргэжлийн 3 номын санчтай.

Анхаарах асуудал:

- Номын сангийн талбайг нэмэгдүүлэх, уншлагын танхимд тав тухтай орчин бүрдүүлэх (зөөлөвчтэй сандал, гэрэлтүүлэг, дуу шуугиан, агааржуулалтыг анхаарах).
- Төгсөгчдөд номын сан ашиглах эрхийг сунгах талаар судалж шийдвэрлэх.

Зөвлөмж:

- Англи номын баяжилт, ашиглалтыг нэмэгдүүлэх.
- Номын сангийн ажиллах хугацааг уртасгах.
- Номын фонд бүрдүүлэлтийг монгол, орос, англи хэл, мэргэжлийн чиглэлээр ангилж, баяжилт, ашиглалтын байдалд дүгнэлт жил тутам хийж байх.

3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж;

хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Илрэл нотолгоо:

Сургуулийн удирдлагын зөвлөлөөс дээд боловсролын байгууллагаас гаргасан тушаал шийдвэрүүд, дүрэм журамтай холбоотой өөрчлөлтүүдийг шат дараатай шинэчлэн боловсруулж хяналт тавьж ажилладаг байна. Сургалтын удирдлага мэдээллийн системийн сайжруулалтыг хийж 2019 оноос эхлэн Cloud University гэсэн үүлэн сиситемийг хэрэглэж байна. Удирдлагууд нь нэгжээс санал асуулгаар сэтгэл ханамжийн судалгааг авч үр дүнг тооцон дүгнэлт гарган ажилладаг байна. Программ нь албад, багш, оюутан, эцэг эхийн гэсэн дэд бүтэцтэй байна. Анагаах ухааны чиглэлээр өрсөлдөх чадвартай мэргэжилтэнг бэлтгэн улс, олон улсын шилдэг сургуулийн нэг болох эрхэм зорилгын хүрээнд Ач АУИС-ийг хөгжүүлэх мастер төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж байна. Тэнхим нэгжүүдтэй нягт хамтран ажиллаж хичээлийн жилийн эхэнд нэгж бүр үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллаж байна. 2014 онд захирлын 057 тоот тушаалаар сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрт шинэчлэл хийсэн байна. 2016-2021 оны хооронд 5 багш докторын зэрэг, 12 багш магистрын зэрэг амжилттай хамгаалсан байна. Үндсэн мэргэжлийн чиглэлээр 7 багш нарийн мэргэжлээр мэргэшсэн, төрөлжсөн мэргэжлээр 10, эмнэлзүйн сургагч багшаар 7, ёс зүйн сургагч багшаар 2 багш тус тус суралцаж мэргэжлээ дээшлүүлсэн байна.

Хөтөлбөрийг сургуулийн хөтөлбөрийн дэд хороогоор хэлэлцүүлэн цаашид хөтөлбөрийн хороогоор үе шаттай хэлэлцүүлж сургуулийн эрдмийн зөвлөлөөр баталгаажуулдаг.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Гэрээт байгууллагуудын ажил үүрэг, сургалтын үйл ажиллагаанд оролцох байдал тогтмолжсон, хамтын ажиллагааны талаарх баримт бичгүүд эмх цэгцтэй
- Олон улсын түвшинд хамтран ажиллах сургалтын байгууллагуудтай

Анхаарах асуудал:

- Зарим гэрээт байгууллагын гэрээний хугацааг нягтлан харах, гэрээг шинэчлэн батлуулж ажиллах

Шаардлага:

- Сургалтын хөтөлбөрт оролцсон багш нар (гэрээт, үндсэн) тухайн хөтөлбөрийг боловсруулсан багш, хянасан тэнхимийн эрхлэгч, хүлээн зөвшөөрсөн сургуулийн удирдлага гэсэн гарын үсгээр баталгаажуулж ажиллах

4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

ОХУ-ын Новосибирск, Япон, Англи, БНСУ, БНХАУ-н Анагаахын сургуулиудтай хамтран ажиллаж шинэлэг мэдээлэл авч сургалтынхаа хөтөлбөр, эрдэм шинжилгээ судалгааны ажлуудад тусган хамтран ажилладаг байна. Үндэсний хэмжээнд мэргэжил нэгт сургуулиудтай хөтөлбөр болон эрдэм шинжилгээ эмнэлзүйн тал дээр туршлага солилцон хамтарч ажиллаж байна. Олон улсын байгууллагуудаас төсөл хэрэгжүүлж тухайлбал Глобол сан, Азийн Хөгжлийн банктай хамтран ажилласан байна. Мэргэжлийн холбоод үйлдвэр үйлчилгээний байгууллагууд, ажил олгогч, эздийн холбоо, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран нийгэмд чиглэсэн үйл ажиллагааг тогтмол явуулж хэвшсэн байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- 20 жилийн түүхэн туршлага нь хамтын ажиллагааг улам хөгжүүлэх боломжийг бүрдүүлсэн байна.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийг удирдан явуулж буй багш нарын мэдлэг мэргэжлийг тогтмол дээшлүүлж байх

Зөвлөмж:

- Хамтын ажиллагаатай гадаадын сургуулиудад урт, богино хугацаагаар багш, оюутан солилцооны хөтөлбөр хэрэгжүүлж ажиллах
- Залуу эрдэмтдийг дэмжих

4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Илрэл нотолгоо:

Санхүү бүртгэлийн хувьд бие даасан. Орлого зардлын бүртгэлийг НББОУС-ын дагуу бүртгэж жил бүр хөндлөнгийн хараат бус аудитаар үнэлгээ хийлгэж хянан баталгаажуулалт хийдэг. Хөтөлбөр хэрэгжүүлэгч Анагаахын төсвийн хувьд бие даасан бус байгууллагын нэгдсэн төсөвт шууд хамааралтай ажилладаг. Сургуулийн нийт оюутны тоо, хамрах хүрээний хувьд сургуулийн нийт төсөв санхүүжилтийн 70-80 хувийг эзэлдэг. Ач АУИС нь үүсгэн байгуулагчдын хөрөнгө, сургалтын төлбөрөөр санхүүжиж ашгийн бус үйл ажиллагаа явуулдаг. Сургалтын төлбөрийг эргүүлэн сургалтын урсгал зардал, хөрөнгө оруулалтанд бүрэн зарцуулдаг байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- 2018 оноос оюутны зардал, сургалтын зардлыг тусад нь бүртгэж оюутны эрдэм шинжилгээ, семинар, тэмцээн уралдаан, шагнал, оюутны дадлага зэрэг зардлуудад зарцуулдаг байна.

Анхаарах асуудал:

- Сургалтын зардлаас яг оюутны суралцах хөтөлбөрийн шинэчлэлд хэрхэн зарцуулдагийг тодруулах шаардлагатай

Зөвлөмж:

- Сургалтын төлбөрөөс гадна үндэсний болон олон улсын чанартай төсөв хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, нэмэлт санхүүжилтийг бий болгох

4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Илрэл нотолгоо:

Хөтөлбөрийг олон нийтэд мэдээлэх зорилгоор сургалтын хөтөлбөрийн санг бүрдүүлж ажилладаг. Сургуулийн вэб хуудсаар дамжуулан 70-100 гаруй мэдээллийн эх сурвалж, танилцуулга брошюр, постер хэвлэлүүдийг байршуулсан байна. Хөтөлбөрийн талаарх санал асуулгыг сургуулийн төгсөгчид, ажил олгогч нараас тандан судалж дүн шинжилгээ хийдэг. Төгсөгчдөөс авсан санал асуулгад харилцаа хандлага, мэргэжлийн суурь, мэргэжилтний эрэлт хэрэгцээ зэрэгт хамгийн өндөр үнэлгээ өгсөн байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад сургууль болон мэргэжил сурталчлах ажлыг зохион байгуулалттайгаар явуулж сургалтын мэдээллүүдийн маркетингийг тогтмол хийдэг болсон.

Зөвлөмж:

- Сургуулийн вэб-ийн үйл ажиллагааг тогтмолжуулах, шинэчлэл хийх

4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Илрэл нотолгоо:

www.ach.edu.mn вэб хуудастай. Анагаах ухаан сургалтын хөтөлбөрийн зорилго, зорилтуудыг нийтэд нээлттэйгээр мэдээллэж байршуулдаг, хөтөлбөрийн талаарх мэдээлэл хангалттай. Дотоод мэдээллийн системээр зөвхөн сургалтын хөтөлбөрөөс гадна тэнхимийн эрхлэгчдийн зөвлөгөөн, захирлын болон эрдмийн зөвлөлийн хурал, эрдэм шинжилгээний хурал, сургуулийн зарим дотоод мэдээллийг тухай бүрд нь дэлгэрэнгүй хүргэдэг байна. Оюутнуудад Google Classroom ашиглан электрон мэдээллийг нээлттэй хүргэж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Анхаарах асуудал:

- Сургалтын хөтөлбөрийг цахимжуулах багш нарын лекц, дадлага, семинарын хичээлийн хөтөлбөрийг багш, оюутны программд оруулах

Зөвлөмж:

- Сургуулийн вэб, мэдээллийг системтэйгээр шинэчлэн, өргөжүүлж байх шаардлагатай

4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Илрэл нотолгоо:

Элсэлтийн бодлого, дүрэм журам

Оюутан элсүүлэх журмыг жил бүр шинэчилж, сургуулийн вэб хуудаст байршуулдаг. Бакалаврын сургалтын хөтөлбөрт 2020-2021 оны хичээлийн жилд оюутан цахимаар элсүүлэх журамд бүртгүүлэгчдэд тавигдах шаардлага, бүртгэх, шалгаруулах, сонгон шалгаруулах, хөнгөлөлттэй нөхцлөөр элсүүлэх, элсэгчдийг бүртгэх асуудлыг тодорхой тусгасан байна. Жил бүрийн элсэгчдийн нэрсийг Ач АУИС-ийн захирлын тушаалаар баталгаажуулдаг (Элсэгчдийн нэр батлах тухай 2015 оны А/50, 2016 оны А/50, 2017 оны А/040, 2018 оны А/053, 2019 оны А/066, 2020 оны А/046, 2021 оны А/049 дүгээр тушаалуудтай танилцсан). Онлайн элсэлтийн бүртгэлийн програм хангамж нийлүүлэх гэрээтэй, элсэлтийн бүртгэлийг burtgel@ach.edu.mn системээр орон зайн хязгаарлалтгүйгээр цахимаар явуулахаас гадна Монголын их, дээд сургуулиудын консорциумтай хамтран аймаг, орон нутгаас оюутан элсүүлэх журмын дагуу зохион байгуулдаг.

Элсэлтийн маркетинг төлөвлөгөө /2017-2021 он/, Ач АУИС-ийг 2017-2021 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө, “Ач” АУИС-ийн оюутны хөгжлийн хөтөлбөр /2020-2025/, баталж, хэрэгжүүлсэн.

Элсэгчдийн ЭШ-ын дундаж оноо, хүсэлт гаргасан болон элссэн суралцагчдын харьцаа

Элсэлтийн журамд ЭШ-ын боломжит оноог 410-аар тогтоосон бөгөөд жил бүрийн анагаахын салбарт элсэгчдийн ЭШ-ын дундаж оноо нь бусад мэргэжлээр элсэгчдийн дундаж онооноос өндөр байна. Анагаахын ангид элсэгчдийн элсэлтийн ерөнхий шалгалтын дундаж оноо нь 2016-2017 оны хичээлийн жилд хими-577, биологи-504, 2017-2018 оны хичээлийн жилд хими-580, биологи-562, 2018-2019 онд хими-562, биологи-552, 2019-2020 онд хими-531, биологи-539, 2020-2021 онд хими-529, биологи-537, 2021-2022 оны хичээлийн жилд хими-553, биологи-556 байсан. Элсэхийг хүссэн болон элсэн суралцагчдын харьцааг 2016 оноос 2021 он хүртэл гаргасан байна: 2016 онд 398 : 135 буюу 3 хүсэлт гаргагч тутмын 1, 2021 онд 1386 : 206 буюу 6-7 хүсэлт гаргагч тутмын 1 нь элсэн суралцсан байна. Өөрөөр хэлбэл тус сургуульд элсэн суралцах хүсэлт гаргагчийн тоо нэмэгдсэн байна. Элсэгчийг элсэлтийн ерөний шалгалтын үндсэн хичээлийн шалгалтын оноо болон дагалдах хичээлийн шалгалтын оноог нэмж, нийлбэр оноогоор эрэмбэлдэг.

Шинэ суралцагчдад зориулсан мэдээлэл, гарын авлага

Оюутны гарын авлагыг жил тутам шинэчлэн хэвлүүлж, нэгдүгээр дамжааны оюутан бүрт гарын авлагыг олгодог, 2-6 дугаар дамжааны оюутнууд цахим хэлбэрээр ашигладаг.

2021 онд хэвлэгдсэн Оюутны гарын авлагад сургуулийн түүхэн замнал, сүлд дуу, бүтэц, шаардлагатай мэйл хаяг, утасны дугаар, оюутны тангараг, лого, энгэрийн тэмдэг, хичээлийн хуваарь, хамрагдах боломжтой тэтгэлэг, тэтгэлэг олгох нийтлэг журам, оюутны хөгжлийн зээл, сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж, сургалтын төлбөрийн 10%-ийн хөнгөлөлт, замын зардлын буцаан олголт, Ач АУИС-ийн Оюутны хөгжлийн хөтөлбөр /2020-

2025 он/, оюутанд баримт бичиг олгох, дахин олгох журам, оюутны ёс зүйн журам, шилжилт, хөдөлгөөний журам, өргөдөл бичих загвар, оюутны үнэлгээний журам, оюутны сайн дурын байгууллагын нийтлэг журам, клуб, нийгэмлэгийн танилцуулга, оюутанд зориулсан үйлчилгээний байгууллага (номын сан, интернет мэдээллийн төв) танилцуулга, дүрэм, сургуулийн эмчийн үйл ажиллагаа, Cloud University оюутны програм, Google education apps програм, оюутны мэйл хаягийн талаар тодорхой тусгасан байна.

4900 орчим гишүүнтэй Оюутны албаны фэйсбүүк групптэй, мэдээлэл тогтмол байршуулж, шинээр элсэгчдийн санал, хүсэлтийг шийдвэрлэдэг. Сургалтын албанаас нэгдүгээр дамжаанд элсэгчдэд зориулж “Нээлттэй хаалганы өдөр” зохион байгуулж, “Оюутны тангараг” өргүүлдэг, оюутан бүртэй “Сургалтын гэрээ” байгуулж, жил тутам гэрээг дүгнэдэг.

Гадаад оюутны элсэлтийн тоо

Ач Аанагаах ухааны их сургуульд Анагаахын хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаанд 1 гадаад оюутан 2019 онд 3.1 голч дүнтэйгээр төгссөн байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Босго оноо бусад мэргэжлээр элсэгчидтэй харьцуулахад өндөр, тус сургуульд элсэн суралцах хүсэлт гаргагчийн тоо нэмэгдсэн.
- Шинээр элсэгчдэд зориулсан гарын авлагын агуулга дэлгэрэнгүй, тодорхой.

Анхаарах асуудал:

- Сургуулийн вэб хуудаст элсэлтийн журмаас өөр мэдээлэл байршуулаагүй, шинэчлэлт удаашралтай байгааг анхаарах.

Зөвлөмж:

- Сургуулийн вэб хуудсыг шинэчлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх, сургуулийн бүх алба, салбар, тэнхимийн оролцоог хангах, зохион байгуулалтыг сайжруулах.
- Оюутан солилцоог бий болгож, гадаад хамтын ажиллагааг сайжруулах.

5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

Зөвлөх, хөгжүүлэх үйлчилгээний төлөвлөгөө, тайлан

Зөвлөн туслах үйл ажиллагааны төлөвлөгөөг жил бүр сургуулийн захирал баталж, гүйцэтгэлээр нь дүгнэж тайлагнадаг. Курсын дарга нарыг томилдог ба нэгдүгээр дамжаанд 2 багш зөвлөн тусалдаг.

Захирлын 2015 оны А/044 дүгээр тушаалаар “Оюутны зуны дадлагын журам”, 2016 оны А/016 дугаар тушаалаар “Оюутны ёс зүйн журам”, 2016 оны А/038 дугаар тушаалаар “Оюутны үнэлгээний журам”, 2019 оны А/022 дугаар тушаалаар “Ач АУИС-ийн дүрэм”-ийг баталж хэрэгжүүлж байна. Их сургуулийн дүрмийн “б. Сургуулийн суралцагч” бүлэгт суралцагчийн амьдрал, сургалттай холбоотой асуудлаар холбогдох албад, байгууллагад хүсэлт тавьж, шийдвэрлүүлэх эрх, сургууль, багш, ажилтны үйл ажиллагаатай холбогдох асуудлаар санал гаргах, шаардлага тавих, эрдэм судлалын ажил, хурал, зөвлөгөөнд оролцох, бүтээлээ хэвлэн нийтлүүлэх эрхийг тусгасан байна.

2022 оны байдлаар тусгай хэрэгцээт/хөгжлийн бэрхшээлтэй 7 оюутан суралцаж байгааг нэмэлтээр гаргуулсан. Тухайлбал хэл ярианы бэрхшээлтэй – 1, нурууны гэмтэлтэй-1, түнхний мултралтай-2, сонсголын бэрхшээлтэй-1 байна.

Сэтгэл ханамжийн судалгаа, баримт материал

Оюутны сэтгэл ханамжийн судалгааг 2018-2019 анкетийн аргаар, 2020-2021 онд цахимаар авсан, цахим хэлбэрээр авсан судалгаанд анагаахын салбарын хөтөлбөрөөр суралцаж буй 237 оюутан хамрагдсан ба судалгаагаар оюутны албаны үйл ажиллагааг “сайн” гэж үнэлсэн ч дараалал ихтэй, хугацаа их алддаг, хүлээлгэдэг, зохион байгуулах арга хэмжээ тодорхойгүй, мэргэжлийн чиглэлийн уралдаан, тэмцээн, спорт, урлагийн арга хэмжээ дутагдалтай гэсэн дүн гарсан.

Зохион байгуулсан сургалт, арга хэмжээний тайлан мэдээ

Оюутны холбоо, сайн дурын клуб, нийгэмлэгүүдээс жил бүр шинэ элсэгч оюутанд сургуулиа танилцуулах өдөрлөг, урлаг, утга зохиол, мэргэжлийн олимпиад тэмцээн, уралдаан зохион байгуулдаг, тухайлбал анатоми, мэс засал, эм судлал, эмгэг судлалын олимпиад, англи хэлний олимпиад, спортын арга хэмжээ зохион байгуулдаг. Суралцагчдад зориулж хувь хүний хөгжил, харилцааны ёс зүй, эрүүл мэндийн шинэчлэл, цаг төлөвлөлт, эмчийн мэргэжлийн онцлог, эзэмших ур чадвар зэрэг 12 чиглэлээр лекц, семинар зохион байгуулдаг.

Эрдэм шинжилгээ судалгааны ажлын тайлан мэдээ

Өөрийн үнэлгээнд дурдсанаар давхардсан тоогоор анагаах ухааны хөтөлбөрөөр суралцагчдын 10 хувь нь ямар нэг байдлаар бүтээл туурвиж хэлэлцүүлсэн буюу оюутны эрдэм шинжилгээний үйл ажиллагаа тогтворжиж буй.

Ач АУИС-аас жил бүр эрдэм шинжилгээний хурал зохион байгуулж, товхимол хэвлүүлж хэвшсэн ба “Оюутны эрдэм шинжилгээний хурал”-ыг хавар, “Эрдмийн чуулган”-ыг намар зохион байгуулдаг. 2013-2022 оны хооронд тавигдсан илтгэлийн жагсаалтыг нэмэлтээр гаргуулахад нийт 416 илтгэл тавигдсанаас Эрдмийн чуулган 2019-д 21 илтгэл, Эрдмийн чуулган 2020-д 42, Оюутны эрдмийн чуулган 2021-д 15, Оюутны эрдмийн чуулган 2022-д 24 илтгэл хэлэлцэгдсэн байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Оюутны эрдэм шинжилгээний хурал, Эрдмийн чуулган зохион байгуулж хэвшсэн.

Анхаарах асуудал:

- Зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж байгаа алба, нэгж, багш нарт чиглэсэн дүрэм, журам шинээр боловсруулж, батлуулах.
- Элсэлтийн маркетинг төлөвлөгөө /2017-2021 он/, Ач АУИС-ийг 2017-2021 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө, “Ач” АУИС-ийн оюутны хөгжлийн хөтөлбөр /2020-2025/-тайланд дүн шинжилгээ хийж, үйл ажиллагаандаа тусгах.

Зөвлөмж:

- Өөрийн үнэлгээний тайланд зөвлөн туслах үйл ажиллагаа, зохион байгуулсан сургалт, арга хэмжээний тайланг нэгтгэж, тоо баримттай тусгах.
- Тусгай хэрэгцээт/хөгжлийн бэрхшээлтэй оюутны мэдээллийг өөрийн үнэлгээний тайланд тусгаж хэвших.
- Үнэлгээний арга хэлбэрүүдийн талаар оюутнуудад тайлбарлаж ойлгуулах, гадаад хэлний мэдлэгийн түвшнийг сайжруулах.

5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

Оюутны клубын зохион байгуулсан арга хэмжээ, тайлан мэдээ

Ач АУИС-ийн дэргэд 1998-2019 оны хооронд байгуулагдсан оюутны сайн дурын 13 клуб, нийгэмлэгийн 11 нь одоогоор идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. Үүнд Оюутны холбоо, Оюутны эрдэм шинжилгээний нийгэмлэг, Залуу мэс засалч клуб, Нүүр ам судлалын оюутны зөвлөл, Эм судлаач оюутан клуб, Nursing club, Basis study клуб, Шийдэл клуб, DRS-CAB яаралтай түргэн тусламж клуб, Эмнэл зүйн ур чадварын клуб, Залуучуудын улаан загалмайн нийгэмлэг. Эдгээр клуб, нийгэмлэгийн 7 нь анагаахын салбарын оюутанд хамаардаг, давхардсан тоогоор 210 оюутан идэвхтэй оролцдог, тухайн чиглэлийн болон нийгмийн сайн дурын үйл ажиллагаа тогтмол хэрэгжүүлдэг.

Клуб, нийгэмлэгийн танилцуулгыг гарын авлага хэлбэрээр 2021 онд хэвлүүлж, оюутны холбоо, клуб, нийгэмлэгүүдийн танилцуулга, бүтэц, дүрэм, үйл ажиллагааг сурталчилсан.

Суралцагчийн гүйцэтгэсэн сайн дурын ажлын үнэлгээ, урамшуулал

Сайн дурын ажлын үнэлгээ, урамшууллын талаар өөрийн үнэлгээний тайланд дурдаагүй байсан тул сайн дурын клуб, нийгэмлэгийн танилцуулгыг нэмэлтээр гаргуулж харахад:

- Оюутны эрдэм шинжилгээний нийгэмлэгийн үйл ажиллагааг гишүүдийн фондны мөнгөөр санхүүжүүлдэг, жилийн санхүүгийн тайлангийн мөнгөн дүн 400000 төгрөг;
- ЗУЗ клуб гишүүдийн хуримтлал, сургуулийн санхүүжилтээр үйл ажиллагаа явуулдаг, жилийн санхүүгийн тайлангийн мөнгөн дүн 1328700 төгрөг;
- Оюутны холбоо нь сургуулийн захиргаа, санхүүгийн алба, гишүүдийн хураамжаар санхүүждэг, сургуулийн захиргаанд шаардлагатай үед албан бичиг хүргүүлж, санхүүжилтийг шийдвэрлүүлдэг, жилийн төсөв 500000-1000000 төгрөг;
- Basis club нь гишүүд, төгсөгч, дэмжигчдийн хандив, клубын үйл ажиллагаанаас олсон орлого, их сургуулийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөнд тусгагдсан тодорхой төсвөөр санхүүждэг, жилийн шаардлагатай төсөв 1000000 төгрөг гэх мэтээр тайлбар өгсөн байна.

Цагийн ажил, үндсэн ажилд зуучилсан төгсөгч, оюутны тоон мэдээлэл

Хөдөлмөрийн тухай хууль, “Орлоготой оюутан” үндэсний хөтөлбөр, тус сургуулийн “Оюутан хөгжүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд Ач интернэшнл эмнэлгийн захирлын 2022 оны 3 дугаар сарын 01-ний 007 тоот тушаалыг баталж, оюутнуудыг зохих ажлын орон тоон дээр цагийн ажилд давуу эрхтэйгээр зуучлах, хөдөлмөрийн гэрээ байгуулж, цалин хөлс олгохоор шийдвэрлэж, тухайн оюутны эцэг, эх, асран хамгаалагчдын зөвшөөрөлтэйгээр ажиллуулж эхэлсэн.

“Орлоготой оюутан” үндэсний хөтөлбөрийн хүрээнд оюутны хөдөлмөр эрхлэх боломжийг хангахад анхаардаг, сургуулийн албан бус судалгаагаар оюутны 2 хувь нь мэргэжлийн чиглэлээр, 11 хувь нь мэргэжлийн бус чиглэлээр цагийн ажил хийдэг.

Олимпиад, уралдаан тэмцээнд оролцсон суралцагчийн тоо, үр дүнгийн мэдээлэл

Олимпиад, уралдаан тэмцээнд оролцогчдын амжилтыг нэр, гаргасан амжилт, эзэлсэн байраар жагсаалтаар гаргасан.

Урамшуулал, тэтгэлэг хөнгөлөлтөд хамрагдсан суралцагчдын тоо

“Шилдэг оюутан шалгаруулах журам”-тай, сургалтын төлбөрөөс 50-100 хувь хөнгөлдөг, сургалтын төлбөрийн 20 хувьтай тэнцэх тэтгэлэг олгодог.

2016-2021 онд анагаахын хөтөлбөрийн нийт 42 оюутан 56,428.000 төгрөгийн хөнгөлөлтөд хамрагдсан байна. Оюутны хөгжлийн зээлд 2017-2021 онд нийт 666 оюутан, төрийн сангийн санхүүжилтэд 263 оюутан, замын зардлын нөхөн олголтод 510 оюутан хамрагдсан байна.

Тэтгэлгийн жагсаалтыг нэмэлтээр гаргуулж харахад: 2021-2022 онд нийт 8 төрлийн тэтгэлэг (БЗС-ОХЗ, БЗС-БТ, АПУ ХК, Дэлхийн зөн ОУБ, Кристина Нобелийн сан, Захирлын тэтгэлэг гм)-т 195 оюутан хамрагдаж 322,220.326 төгрөгөөр, 2020-2021 онд нийт 9 төрлийн тэтгэлэг (БЗС-ОХЗ, БЗС-БТ Дэлхийн зөн ОУБ, Кристина Нобелийн сан, Зориг сан, Дорнод аймгийн Засаг даргын тамгын газар, Захирлын тэтгэлэг гм)-т 206 оюутан хамрагдаж 337,244,890 төгрөгөөр, 2019-2020 онд нийт 5 төрлийн тэтгэлэг (БЗС-ОХЗ, БЗС-БТ, Дэлхийн зөн ОУБ, Тайван Монголын худалдааны нийгэмлэг, Захирлын тэтгэлэг)-т 255 оюутан хамрагдаж 380,147.712 төгрөгөөр урамшуулал тэтгэлэг авсан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Захирлын тэтгэлэгт хөтөлбөртэй, олон улсын байгууллагын болон орон нутгийн засаг захиргааны тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах боломжтой.
- Ач интернэшнл эмнэлэгт цагийн ажилд давуу байдлаар ажиллах боломж бүрдүүлсэн.
- Сайн дурын клуб, нийгэмлэгийн үйл ажиллагааг зохицуулах нийтлэг журамтай.

Анхаарах асуудал:

- Олимпиад, клуб, цагийн ажил, эрдэм шинжилгээний ажил зэрэгтэй холбоотой судалгааг он дарааллаар ойлгомжтой байдлаар гаргаж хэвших.
-

Зөвлөмж:

- Сайн дурын ажлын үнэлгээ, хамрах хүрээ, урамшуулал тодорхой болгох, сургуулийн санхүүжилтийг нэмэгдүүлэх.
- Цагийн ажил, үндсэн ажилд зуучилсан төгсөгч, оюутны судалгаа тогтмолжуулах.
- Олимпиад, уралдаан тэмцээнд оролцсон суралцагчийн тоо, үр дүнг төрөлжүүлж ангилах, ойлгомжтой байдлаар тусгах.

5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Илрэл нотолгоо:

Суралцагчийн шилжилт хөдөлгөөний судалгаа

Сургуулийн захирлын 2015 оны 028 дугаар тушаалаар “Оюутны шилжилт, хөдөлгөөний журам”-ыг баталж, мөрдөж ажилладаг. Шилжилт хөдөлгөөнийг түр чөлөөлөх, шилжин ирэх, салбар солих, шилжиж явах, цуцлах, улирах, жилийн чөлөө авах, сургуулиас гарах, үргэлжлүүлэн суралцах гэж ангилж, тайланг жил тутам гаргадаг. Сүүлийн 5 жилд Анагаахын салбарт суралцагчдаас 111 оюутан чөлөө авсан, 121 оюутан шилжиж ирсэн, 39 оюутан салбар солих хүсэлт гаргаж, шийдвэрлүүлсэн, 189 оюутан бусад их, дээд сургуулиуд руу шилжсэн, 18 оюутан эрүүл мэнд, ар гэрийн гачигдлын улмаас өөрийн хүсэлтээр суралцах гэрээг цуцлуулан байна, сургуулийн зүгээс санаачлан оюутны гэрээг цуцалсан тохиолдол тайлант хугацаанд гараагүй байна.

Багц цагийн дүйцэл, шилжилт хөдөлгөөний судалгаа, дүрэм журам

Гадаад, дотоодын бусад их, дээд сургуулиас оюутан өөрийн хүсэлтээр ирж суралцах боломжтой, хүсэлт гаргасан оюутны албан ёсны дүнг Сургалтын бодлого зохицуулалтын

алба багц цагаар дүйцүүлэн тооцож, “Оюутны шилжилт, хөдөлгөөний журам”-ын дагуу зөрүү байхгүй бол сургуулийн захиралд хүсэлтийг шилжүүлж шийдвэрлүүлдэг тогтолцоотой. Сургуулийн бусад хөтөлбөрийн оюутнаас Анагаах ухааны хөтөлбөрт шилжин суралцах хүсэлтийг хичээлийн жилийн улирлын эхэнд бусад хөтөлбөрийн оюутнуудаас авч, Захирлын зөвлөлөөр хэлэлцэж шийдвэрлэдг. Хүсэлт гаргасан оюутны сурлагын голч дүн, өргөдөл зэргийг харгалзаж үздэг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Оюутны шилжилт, хөдөлгөөний журамтай, оюутны гарын авлагад тусгасан.

Анхаарах асуудал:

- Сургуулийн вэб хуудаст шилжилт, хөдөлгөөн, багц цагийн дүйцлийн талаар мэдээлэл байхгүй, холбогдох журмыг байршуулаагүй.

Зөвлөмж:

- Сургуулийн вэб хуудаст холбогдох мэдээллийг байршуулах, тогтмол шинэчлэх.

5.5. Төгсөлтийн баримт бичиг

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

Илрэл нотолгоо:

Төгсөлтийн баримт бичгийн загвар

“Боловсролын баримт бичгийн загвар шинэчлэх батлах тухай” Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2012 оны 01 дүгээр тушаалаар баталсан загварын дагуу үнэт цаас байдлаар хэвлүүлж, олгодог. Дипломын хавсралтад оюутны овог, нэр, регистр, мэргэжлийн нэр, индекс, боловсролын зэрэг, судалсан хичээлүүдийн нэр, багц цаг, сурлагын рейтинг, голч дүнг тусгадаг. Диплом, дипломын хавсралт бүр нууцлалтай.

Төгсөлтийн баримт бичгийг олгох дүрэм журмын хэрэгжилтийн байдал

Хүний их эмч мэргэжлээр 2004-2021 онд нийт 2189 төгсөгчтэй. Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/164 дүгээр тушаалаар баталсан “Их эмчийн тангараг өргөх журам”-ын дагуу төгсөгчид “Их эмчийн тангараг” өргөж, төгсөлтийн баримт бичгийг хүний их эмчийн тамгын хамт гардаж авдаг. 2016-2021 онд олгосон 11 Онцгойлох дипломын 2 нь Хүний их эмч мэргэжлээр төгсөгчдөд хамаарна. Онцгойлох дипломтой төгсөгчдийн нэрсийг Ач АУИС-ийн захирлын тушаалаар тусад нь хавсралтаар батлуулж, төгсөлтийн баримт бичгийг олгосон байна. Төгсөгч бүрийн дипломын 1 хувийг, анкет, өмнөх шатны боловсролын бичиг баримтын хуулбарын хамт байнгын архивын нэгж болгож хадгалдаг.

Төгсөгчдөд оюутны албанаас регистрийн дугаар, дипломын дугаар, бүртгэлийн дугаар бүхий тодорхойлолт олгодог. Мөн гадаад улсад суралцах хүсэлтэй төгсөгчдөд англи хэлээр тодорхойлолт олгодог.

Алдсан, хаясан, гээгдүүлсэн дипломыг дардас хэрэглэхгүй гарын үсгийг зуруулдаг. 2016-2021 онд нөхөн олгосон төгсөлтийн баримт бичгийн судалгааг нэмэлтээр гаргуулахад: алдсан, галд үрэгдсэн, хаяж үрэгдүүлсэн, овог солиулах гэсэн шалтгаанаар төгсөлтийн баримт бичиг-дипломыг 9 төгсөгчид нөхөн олгосны 5 нь Хүний их эмч мэргэжлээр төгсөгч байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Cloud University системд оюутны элсэлтээс эхлээд төгсөлт хүртэлх сургалтын үзүүлэлт, мэдээллийг цогц байдлаар харах, дипломын хавсралтыг хэвлэх үйл ажиллагаа хэвшсэн.

Зөвлөмж:

- Онцгойлох диплом олгосон төгсөгчдийн тоо, төгсөлтийн баримт бичиг нөхөн олгосон тоо, судалгааг өөрийн үнэлгээний тайланд тусгах.

5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Илрэл нотолгоо:

Хөтөлбөрийн хүний нөөцийн цогц бодлогын баримт бичиг, хэрэгжилтийн тайлан
“Ач” АУИС-ийг хөгжүүлэх мастер төлөвлөгөө, стратеги төлөвлөлтийн хүрээнд “Хүний тогтвортой хөгжил, өрсөлдөх чадвар”-ыг дээшлүүлэх, хүний нөөцийн хөгжлийн талаар баримтлах бодлого чиглэлийг тусган ажиллаж байна. “Багшийн залгамж холбоо-залуу багш бэлтгэх хөтөлбөр” хэрэгжүүлж эхэлсэн нь багшийн хөгжил, залгамж холбоо үүсгэх, хүний нөөцийг бүрдүүлэхэд ач холбогдолоо өгч байгааг тэмдэглэсэн байна.

Доктор зэрэгтэй багш нарын эзлэх хувийн жин, судалгаа /сүүлийн 5 жилээр/

Анагаах ухаан хөтөлбөр хэрэгжүүлэгч багш нарын бүрэлдхүүнд профессор 10, дэд профессор 5, ахлах багш 13, багш 28, дадлагажигч багш 5 байна. 2021 оны байдлаар 14 тэнхимд үндсэн багш 61 ажиллаж байгаа бөгөөд сүүлийн 5 жилд сонгон шалгаруулж авсан багш нарын 80% нь эрдмийн зэрэг цолтой багш нар байна. Сүүлийн 5 жилд 5 багш докторын зэргээ амжилттай хамгаалсан байна. Докторын зэрэг, цолтой 8 багш сонгон шалгаруулалт болон урилгаар тэнхимийн эрхлэгч, багшийн албан тушаалд ажиллаж байна. Багш нарын 37,7% нь тус сургуульд 10-с дээш жил ажиллаж байгаа судалгаа байна.

Багш, суралцагчдын тооны зохистой харьцааны судалгаа

Багш, суралцагчдын тооны зохистой харьцааг зохистой хэмжээнд барих асуудалд ихээхэн анхаарч ажилладаг. Нэг багшид оногдож буй оюутны тоо 13-17 хооронд хэлбэлзэж байна. Сургалтын чанарыг эрхэмлэх зорилгоор багш, оюутны тооны зохистой харьцааг хүний их эмчээр суралцаж буй оюутнуудын хэсэг бүрд 16-с хэтрүүлэхгүй байхаар төлөвлөн ажиллаж байна.

Багшийн албан тушаалын зэрэглэлийн ангилалд тавигдах шаардлагад нийцсэн байдлын судалгаа

Захирлын 2016 оны 09 сарын 05-ны өдрийн А/41 тоот тушаалаар батлагдсан “Багш нарын ачаалал тогтоох, гүйцэтгэлийг тооцох” журмыг мөрдөн ажиллаж байна. Багшийн ур чадвар, эрдмийн зэрэг цолоос хамааран багшийн ачааллыг тогтоодог байна. Багш нарын цагийн ачааллыг албан тушаалыг зэрэглэлээс хамааран сургалт, эрдэм шинжилгээ, мэргэжлийн үйл ажиллагаа хэмээн задалж нийт 32 кредитийг биелүүлэхээр тооцож мөрдөн байна.

Профессор нь сургалт, эрдэм шинжилгээнд, дадлагажигч багш сургалтын үйл ажиллагаанд илүү ачаалал гүйцэтгэхээр төлөвлөсөн байна. 5 жилийн хугацаанд шинээр 50 багш ажилд авснаас сургууль төгссөн 19, багшлах ажлын туршлагатай 20, бусад байгууллагаас шилжиж ирсэн 11 байжээ.

Багшийн цагийн ачаалал ачаалал тооцсон судалгаа

Хичээлийн жилд багш 32 кредит биелүүлэхээр төлөвлөсөн байна. Профессор сургалтаар 12, эрдэм шинжилгээ 12, мэргэжлийн үйл ажиллагаа 8, дэд профессор 13:11:8 ахлах багш 14:10:8, багш 15:8:9, дадлагажигч багш 16:6:10 байхаар тус тус байхаар тооцсон байна. Багш нарын биелүүлсэн цагийн ачааллыг авч үзэхэд нэг багш хичээлийн жилд биелүүлэх кредитээ цагаа нэг дахин давуулан биелүүлсэн байдал ажиглагдлаа.

Багш нарт олгосон урамшууллын судалгаа

Багш нар үндсэн цалингаас гадна албан тушаал, цол, мэргэжлийн зэрэг, автобус унаа, ур чадварын нэмэгдлийг авдаг байна. Багш нарын ажил үүргийн биелэлтээс хамаарч цалинг 10-15 хүртэл хувиар нэмэх, хасах эрхийг захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэдэг байна. Багш нарт олгосон илүү цагийн хөлс 2016-2017 оны хичээлийн жилд 25,098,375 байсан бол 2019-2020 онд 114,200,732 болсон байна. 2016 оны байдлаар багшийн дундаж цалин 703,272 байсан бол 2020 оны байдлаар 790,575 болжээ. Багш нартай уулзах уулзалтаар багш нар цаг үеийн байдалтай холбогдуулан цалинг үе шаттай нэмэх саналыг дэвшүүлж байлаа. Сүүлийн 5 жилийн хугацаанд давхардсан тоогоор 56 багш төрийн болон Засгийн газрын шагналаар шагнагдсан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Эрдмийн зэрэг цолтой, эрүүл мэндийн болон боловсролын салбарт тэргүүлэх, танигдсан, туршлагатай багшлах боловсон хүчний бүрэлдхүүн ажиллаж байна.

Анхаарах асуудал:

- Багш, дадлагажигч багш нарын мэргэжлийн мэдлэг, чадвар, хандлагыг дээшлүүлэх төлөвлөгөө боловсруулан, үр дүнг тооцон ажиллах

Зөвлөмж:

- Тухайн хичээлийн ачааллыг жил бүр сайтар тооцож, багшийн ачааллыг зохистой хэмжээнд барих
- Шинэ төгсөгчдийг багшаар ажиллуулахдаа мэргэжлийн мэдлэг, чадварыг дээшлүүлэх бэлтгэлийг сайтар хийх төлөвлөгөө гаргах, хичээлд нь сууж мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгсөн тайлантай байх

6.2. Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Илрэл нотолгоо:

Багшлахуйн ур чадвар, судалгааны ур чадвар, суралцах хэрэгцээг тодорхойлсон судалгаа, судалгааны дагуу хийсэн ажлын баримт

“Багш хөгжлийн төв”-ийг 2013 онд байгуулсан байна. Багшлах бүрэлдхүүний хөгжлийн хэрэгцээг 2 жил тутам судалж, үр дүнд тулгуурлан цаашид хөгжүүлэх төлөвлөгөө гарган ажилладаг байна. “Ач” Анагаах ухааны их сургуулийн багшлах бүрэлдэхүүний сургалт, эрдэм шинжилгээ, мэргэжлийн хүрээнд бэлтгэгдсэн байдал, цаашдын хөгжлийн хэрэгцээг тодорхойлох зорилгоор 2018 оны 11-р сард “Ач” АУИС-ийн багш нараас 6 бүлэг бүхий онлайн асуумж судалгааг google form ашиглан авсан байна. Судалгаанд 59 багш оролцсон бөгөөд онолын 57.6%, эмнэлзүйн 44.1% багш оролцож; анагаах ухааны боловсрол судлалын сургалтанд хамрагдах, клиникийн төрөлжсөн нарийн мэргэжлийн сургалтуудад хамрагдах нөхцлийг бүрдүүлэх, судалгааны төсөл бичих, олон улсын сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх, илтгэх ур чадварыг дээшлүүлэх асуудалд анхаарахыг багш нар дэвшүүлжээ. Багшийн залгамж холбоо-Залуу багш бэлтгэх хөтөлбөрөөр АУБС, багшийн ёс зүй, багшийн төлөвшил, сурган заах арга зүй, үнэлгээний арга зүй, хөтөлбөр стандарт боловсруулах, мэргэжлийн англи хэл мэдлэг олгох сургалтууд зохиогддог байна.

Багшийг гадаад, дотоодод мэргэжил дээшлүүлж чадавхжуулсан судалгаа

2016-2022 оны хугацаанд давхардсн тоогоор 20 орчим багш гадаадад суралцах, олон улсын хурал зөвлөгөөнд оролцох зэргээр мэргэжил дээшлүүлсэн байна. П.Пунсалдулам ОХУ-д докторын зэрэг, Б.Чимэглхам Япон улсад докторын зэрэг хамгаалжээ. Ж.Дэчмаа, Н.Лхагважав нар Солонгос улсад мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдсан байна. П.Пунсалдулам, Ц.Гүндэгмаа, Ж.Сарантуяа нарын 6 багш Англи улсад их сургуультай танилцах уулзалтад оролцжээ. Ш.Сайндэлгэр, Б.Лхамдулам нар Харвардын анагаахын сургуулийн хэрэгжүүлж буй T2T хөтөлбөрт сургалтанд суралцсан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багш нарыг багаар нь суралцуулах, анагаах ухааны боловсрол судлалын чиглэлээр багш нарт сургалт зохион байгуулж байна.

Анхаарах асуудал:

- Багш нарын гадаад хэлний мэдлэгийг тууштай дээшлүүлэх тал дээр анхаарах

Зөвлөмж:

- Багш хөгжлийн төлөвлөгөөний биелэлтийг хянаж, үр дүнг тооцох

6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Илрэл нотолгоо:

Боловсролын болон шинжлэх ухааны шинэ туршилт, инноваци, ашигтай загвар, патентийн тоон судалгаа

“Ач” АУИС-ийн эрдэмтэн, багш нар нийт 22 бүтээлд ашигтай загвар болон зохиогчийн эрхийн гэрчилгээ авсан байна. 2021 оны байдлаар эрдэм шинжилгээний ажлын тайлан 2, эрдэм шинжилгээний өгүүлэл 10, өгүүлэл 25 дотоодод, илтгэл 18, бичсэн ном, товхимол 4, эрдмийн ажлын удирдагч 3, албан ёсны шүүмж 6 хийсэн байна.

Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр, судалгааны ажил, эшлэгдсэн тоо

Шинжлэх ухаан технологийн сангаас санхүүжүүлсэн “Монгол хүүхдийн зарим булчирхайлаг эрхтний хэвийн бүтэц зүйн судалгаа” суурь судалгааны нэг бүлгийг хэрэгжүүлсэн байна. 2013-2022 оны хооронд 369 эрдэм шинжилгээ, судалгааны өгүүллээс иш татжээ. 2017-2021

оны хугацаанд эрдэм шинжилгээ, судалгааны ажилд 264,634.900 төгрөгийг төсөвлөн зарцуулсан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- “Ач” АУИС-д манай орны төдийгүй олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эрдэмтэн, профессор багш нарын баг ажиллаж байна.
- Багш нарын эрдэм судлалын ажлыг дэмжин ажиллаж, тайлант хугацаанд зохиогчийн эрх, эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэл олныг туурвисан байна.

Анхаарах асуудал:

- Хийсэн ажлаа тайланд тодорхой тусгаж байхыг цаашид анхаарах

Зөвлөмж:

- Залуу багш нарыг эрдмийн ажилд тэмүүлэх урам зоригийг сэргээх, дэмжих

6.4. Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Илрэл нотолгоо:

Багшийн өөрийн үнэлгээний тайланг үнэлэх дүгнэх журам, хэрэгжилтийн тайлан

Багш нар өөрийн үнэлгээний тайланг сургалт, эрдэм шинжилгээ, мэргэжлийн үйл ажиллагаа чиглэлд бичдэг. СБЗА-наас багш нарын өөрийн үнэлгээний тайланд дүн шинжилгээ хийж, зөвлөн тусалдаг байна.

Хөндлөнгийн үнэлгээний тайлан

Өөрийн үнэлгээний тайлангаас гадна удирдлага, хамт олны үнэлгээ, оюутны сэтгэл ханамжийн судалгааны нэгдсэн дүнгээр багшийн ажлыг үнэлдэг. Багшийн үйл ажиллагаанд 360 хэмийн үнэлгээ ашигладаг. Түүнчлэн багш нарын аттестатчилалын шалгатыг зохион байгуулдаг байна. Тухайлбал:Захирлын 2017 оны 11 дүгээр сарын 03-ны А/58 тоот тушаалын дагуу 61 үндсэн багшийн ажлыг үнэлэх ажлыг зохион байгуулж, 5 ахлах багш дэд профессорын орон тоонд, 3 багш ахлах багш, 1 дадлагажигч багш багшийн албан тушаалд дэвшсэн байна.

Багшийн хавтас

Үндсэн багш бүр “Багшийн хавтас”-тай байна. 5 багшийн хавтастай танилцахад Төрийн албан хаагчийн маягт, төгссөн сургуулийн диплом, мэргэжил дээшлүүлсэн гэрчилгээ, сертификат, заадаг хичээлийн хөтөлбөр, үзүүлэн, шалгалтын сорил зэрэг материалууд бүрэн байлаа.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Олон жил тогтвор суурьшилтай ажиллаж байгаа хүний нөөц байна.
- Эрдэм шинжилгээ, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх чадварлаг хүний нөөцтэй.

Анхаарах асуудал:

- Багш хөгжлийн цогц хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг тооцож ажиллах

Зөвлөмж:

- Багш нарын цалинг нэмэх, урамшууллын үнэлгээг дээшлүүлэх асуудалд үе шаттай төлөвлөгөөтэй ажиллах,

6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

Илрэл нотолгоо:

“Сургалтын технологи чанарын хяналтын журам” нь сургалтын бүхий л түвшинд тогтмол үнэлгээ хийж үнэлгээний үр дүнд суурилсан нотолгоо бүхий дүгнэлт гаргаж сургалтын үйл ажиллагааг боловсронгуй болгох чанарын баталгаажилтыг хангахад чиглэгдсэн үйл ажиллагааг хэрэгжүүлж, хэрэгжилтэнд сургалтын бодлого зохицуулалтын албанаас хяналт тавьж ажилладаг байна. Бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагын дагуу хөтөлбөрийн хороо байгуулагдсан. Хөтөлбөрийн хэрэгжилтэнд хөтөлбөрийн хороо жил бүр үнэлгээ өгч явцын үнэлгээ, гүйцэтгэлийн үнэлгээ, үр нөлөөний үнэлгээ, хөтөлбөрийн чанарын үнэлгээг тодорхой давтамжтайгаар хийж үр дүнг үйл ажиллагаандаа хэрэглэж байна. Бүрэлдэхүүн сургуулиас ирсэн хөтөлбөрийг, хөтөлбөрийн хороо хянаж ирүүлсэн саналыг ерөнхий хороо хэлэлцэн захирлын тушаалаар баталгаажуулдаг байна. Багш, оюутан, төгсөгчдийн сэтгэл ханамжийн судалгааг тогтмол хийж хэвшсэн байна.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багш, оюутан, төгсөгчдөөс сэтгэл ханамжийн судалгааг тогтмол хийж хэвшсэн байна.

Анхаарах асуудал:

- Сэтгэл ханамжийн судалгаанаас гарсан үр дүнг сургалтын хөтөлбөрт хэрхэн тусгах, нэгжээс гарсан саналыг хөтөлбөрийн хороогоор хэлэлцүүлэн шат дараатай хэлэлцүүлж баталгаажуулах шаардлаатай байна.

Шаардлага:

- Хөтөлбөрийн хороо, захирлын зөвлөлөөр хэлэлцүүлж баталгаажуулсан хөтөлбөрийг шинэчилсэн тохиолдолд нотлох баримт хурлын тэмдэглэл зэргээр баталгаажуулж хадгалах шаардлагатай.

7.2. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна..

Илрэл нотолгоо:

Эрүүл мэндийн салбарын эрэлт хэрэгцээнд нийцсэн мэдлэг, чавдар, хандлагатай хүний их эмчийг бэлтгэн гаргахад сургалтын технологи, чанарын баталгаажилтын журам зохицуулж байна. Төгсөгчдийн ажил эрхлэлт, ажлын байрны тодорхойлолт, сэтгэл ханамжийн талаарх

судалгааг 1-3 жилийн давтамжтайгаар авч дүн шинжилгээ хийж үйл ажиллагаандаа тусган ажилладаг байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Төгсөгчдийн 58 хувь нь төрийн байгууллагын эмнэлгүүдэд, 40.7 хувь нь хувийн эмнэлгүүдэд ажиллаж байна.
- Суралцсан хөтөлбөр нь ажлын байрны хэрэгцээ шаардлагыг хэр хангаж байгааг үнэлэхэд 64.9 хувь нь маш сайн, 30,5 хувь нь сайн гэж хариулсан байна.

Анхаарах асуудал:

- Үр дүнд суурилсан хөтөлбөрөөр суралцагчдын “Мэргэжилтний цогц чадамж”-ыг (BluePrint) боловсруулж ажиллах

Зөвлөмж:

- Чанарын дотоод баталгаажуулалтын алба байгуулах, хөтөлбөрт бодит хяналт үнэлгээ хийж хэвших

7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

“Ач” АУИС-ийн “Анагаах Ухаан” бакалаврын хөтөлбөр нь үндэсний хэмжээнд нэг удаа магадлан итгэмжлэгдсэн байна. 2015 онд хийгдсэн шинжээчдийн өгсөн зөвлөмжийн дагуу шинэчлэл өөрчлөлтүүдийг хийж эрэлт хэрэгцээнд нийцсэн хүний нөөцийг зах зээлд бэлтгэн нийлүүлж байна

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хүний их эмчийг бэлтгэж хөдөлмөрийн зах зээлд нийлүүлсэн 20 жилийн түүхэн туршлагатай
- Сургалтын бааз эмнэлэгтэй болсон.

Анхаарах асуудал:

- Ази Номхон далайн бүсийн гадаадын хөндлөнгийн шинжээчдийн үнэлгээ хийлгэх

Зөвлөмж:

- Байгууллагын эрхэм зорилго, алсын хараа, мастер төлөвлөгөөтэй уялдуулан цаашид хөтөлбөрийг гадаадын магадлан итгэмжлэлд хамруулах

7-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

ДҮГНЭЛТ

Ач анагаах ухааны их сургуулийн хэрэгжүүлж буй Анагаах ухаан /D091201/ хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайланд хөндлөнгийн үнэлгээ хийсэн шинжээчийн баг шалгуур, шаардлага бүрийг дараах байдлаар үнэллээ.

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан	Хангаагүй (0)	Үндэслэл, шалтгаан
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	2	1.3		Бүрэн хангасан
2	Сургалтын үйл ажиллагаа	3			Бүрэн хангасан
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	3			Бүрэн хангасан
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	4	4.1		Бүрэн хангасан
5	Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	5			Бүрэн хангасан
6	Багшийн үйл ажиллагаа	4			Бүрэн хангасан
7	Чанарын үнэлгээ, баталгаажилт	2	7.1		Бүрэн хангасан
Бүгд		23	3		Бүрэн хангасан
Дүгнэлт		БҮРЭН ХАНГАСАН			

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг Ач анагаах ухааны их сургуулийн “Анагаах ухаан” бакалаврын хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул шалгуурыг “БҮРЭН ХАНГАСАН” гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг Эрүүл мэндийн чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг Д.Мягмарцэрэн

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг..... Т.Алтанцэцэг

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг..... Д.Баярмаа

НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ

Шалгуур	Зөвлөмж
Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт	<ul style="list-style-type: none"> • Цаашид хөтөлбөрийг боловсронгуй болгох, улмаар анагаах ухааны боловсрол судлалыг хөгжүүлж багш нарын хөтөлбөр боловсруулах, үнэлгээ хийх, оюутныг дүгнэх, сургалтын арга зүйг боловсруулахад идэвхи санаачилгатай, тэгш оролцоог хангаж ажиллах шаардлагатай. • Гардан үйлдэл хийх боломжгүй нөхцөлд багш нар эмнэл зүйн сургалтыг тохиолдолд суурилсан тухайлбал: /OCSE,OSPE/ хэлбэрээр зохион байгуулах, шалгах хуудсыг хийсэн, хийгээгүй гэсэн байдлаар өөрөөр хэлбэл /yes.no/ гэсэн оноогоор дүгнэж оюутан бүрийг жигд оролцуулан асуудал шийдэх, шийдвэр гаргах түвшинд зохион байгуулах
Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> • Анагаах ухаан сургалтын хөтөлбөрийн ерөнхий суурь 28, мэргэжлийн суурь 59, мэргэшүүлэх 105 зохистой харьцаанд дүн шижилгээ хийж өөрийн сургалтын онцлогийг харуулах нь зүйтэй. • Сургалтын нэгдсэн төлөвлөгөөнд дүн шинжилгээ, багш, суралцагчдын ачаалал тооцсон судалгааг тогтмол хийх • Хичээлийн сэдэв тус бүр, тухайн сэдвийн агуулгад тохирсон сургалтын арга, хэлбэрийг сонгох тал дээр анхаарч, хичээлийн хөтөлбөрт тодорхой тусгах
Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	<ul style="list-style-type: none"> • Эмнэл зүйн ур чадвар, гардан үйлдлийн кабинет/өрөөг нэмэгдүүлэх, манекен, муляж, хэрэглэгдэхүүний тоо, төрлийг нэмэгдүүлэх, шинэчлэх. • Сургалтыг цахимжуулах чиглэлээр хийгдсэн үйл ажиллагааг тайланд тодорхой тоо баримттай дурдах. • Номын сангийн ажиллах хугацааг уртасгах, номын фонд бүрдүүлэлтийг монгол, орос, англи хэл, мэргэжлийн чиглэлээр ангилж, баяжилт, ашиглалтын байдалд дүгнэлт жил тутам хийж байх
Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	<ul style="list-style-type: none"> • Хамтын ажиллагаатай гадаадын сургуулиудад урт, богино хугацаагаар багш, оюутан солилцооны хөтөлбөр хэрэгжүүлж ажиллах, залуу эрдэмтдийг дэмжих • Сургалтын төлбөрөөс гадна үндэсний болон олон улсын чанартай төсөв хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, нэмэлт санхүүжилтийг бий болгох
Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> • Оюутан солилцоог бий болгож, гадаад хамтын ажиллагааг сайжруулах. • Тусгай хэрэгцээт/хөгжлийн бэрхшээлтэй оюутны мэдээллийг өөрийн үнэлгээний тайланд тусгаж хэвших. • Сайн дурын ажлын үнэлгээ, хамрах хүрээ, урамшуулал тодорхой болгох, сургуулийн санхүүжилтийг нэмэгдүүлэх.
Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> • Тухайн хичээлийн ачааллыг жил бүр сайтар тооцож, багшийн ачааллыг зохистой хэмжээнд барих • Залуу багш нарыг эрдмийн ажилд тэмүүлэх урам зоригийг сэргээх, дэмжих • Багш нарын цалинг нэмэх, урамшууллын үнэлгээг дээшлүүлэх асуудалд үе шаттай төлөвлөгөөтэй ажиллах

Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт	<ul style="list-style-type: none"> • Чанарын дотоод баталгаажуулалтын алба байгуулах, хөтөлбөрт бодит хяналт үнэлгээ хийж хэвших • Байгууллагын эрхэм зорилго, алсын хараа, мастер төлөвлөгөөтэй уялдуулан цаашид хөтөлбөрийг гадаадын магадлан итгэмжлэлд хамруулах
Шаардлага	
Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт	<ul style="list-style-type: none"> • Тухайн хичээлийн төгсгөлд оюутанг хэрхэн, яаж үнэлэх үнэлгээний аргачлал тодорхой бус, багшийн удирдлаган дор хийх үйлдэл хэмжигдэхүүн ойлгомжгүй юуг сонссон, харсан, хийсэн, чадсан гэдэг дээр анхаарч үнэлгээг оновчтой болгож хөтөлбөрт тусгаж ажиллах
Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	<ul style="list-style-type: none"> • Сургалтын хөтөлбөрт оролцсон багш нар (гэрээт, үндсэн) тухайн хөтөлбөрийг боловсруулсан багш, хянасан тэнхимийн эрхлэгч, хүлээн зөвшөөрсөн сургуулийн удирдлага гэсэн гарын үсгээр баталгаажуулж ажиллах
Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт	<ul style="list-style-type: none"> • Хөтөлбөрийн хороо, захирлын зөвлөлөөр хэлэлцүүлж баталгаажуулсан хөтөлбөрийг шинэчилсэн тохиолдолд нотлох баримт хурлын тэмдэглэл зэргээр баталгаажуулж хадгалах шаардлагатай.

IV.Ярилцлагад оролцогчдыннэрс

I. Багш нарын нэрс

№	Овог нэрс	Албан тушаал	Заадаг хичээл	Утас
1	Т.Энхжаргал	Ахлах багш	Ерөнхий хими	99050152
2	Ц.Болорзаяа	Ахлах багш	Морфологи	95283325
3	З.Болорцэцэг	Багш	Биохими	99002015
4	О.Тунгалаг	Дадлагажигч багш	Бичил амь судлал	98087979
5	П.Пунсалдулам	Тэнхимийн эрхлэгч	Эмгэг физиологи	88003877
6	Б.Булганцэцэг	Тэнхимийн эрхлэгч	Сувилахуй	99283844
7	Н.Туяа	Ахлах багш	Сэтгэцийн өвчин	99190538
8	Б.Чимэглхам	Дэд профессор	Мэдрэлийн өвчин	94064361
9	Ц.Гүндэгмаа	Дэд профессор	Эм судлал	99132174
10	Э.Уянга	Дадлагажигч багш	Чих хамар хоолой	88055064

II. Оюутны нэрс

№	Оюутны нэрс	Оюутны код	Курс	Сонгосон байдал	Утас
1	Э.Шинэ-Од	MD18B016	4	Ангийн дарга	99578404
2	З.Баярсайхан	MD14B046	3	Ангийн дарга	95128313
3	Б.Нандин-эрдэнэ	MD21B189	1	Ангийн дарга	80994900
4	Т.Түвшинжаргал	MD18B186	4	Клубын гишүүн	89611941
5	З.Мөнгөнзул	MD17B042	5	Клубын гишүүн	80918011
6	Ч.Наранзул	MD18B181	4	Клубын гишүүн	80292930
7	Б.Хонгорзул	MD18B187	4	Клубын гишүүн	80181097
8	Б.Ундрах	MD20B166	2	Клубын гишүүн	99684678
9	Н.Батням	MD18B036	4	Курсийн дарга	88252408
10	Д.Цэрэнтогтох	MD16B054	6	Курсийн дарга	99470777
11	Б.Хишигжаргал	MD20B106	2	Оюутан	80730022

12	Б.Шинэбаяр	MD19B012	3	Оюутан	89348435
13	М.Энхжин	MD20B078	2	Оюутан	99652298
14	А.Сансармаа	MD17B022	5	Оюутны дотуур байранд амьдардаг	99035845
15	Л.Цэцэгсүрэн	MD18B015	4	Оюутны холбооны тэргүүн	88591308
16	Л.Долгормаа	MD16B047	6	Сурлагын голч дүнгээр	99758586

III. Ажил олгогчдын нэрс

№	Ажил олгогчид	Байгууллага, албан тушаал	Утас	Цахим хаяг
1	Ц.Батболд	Амгалан газар, захирал амаржих	88888119	tseleejavbatbold@gmail.com
2	Н.Мөнхцэцэг	Амгалан газар, Төлөвлөлт ажиллагаа дэд захирал амаржих үйл эрхэлсэн	91496464	muukii.nyamaa@gmail.com
3	Э.Галбадрах	ГССҮТ, Захирал	99060509	galba.mgl@gmail.com
4	Ц.Олонбаяр	СХД, Хүүхдийн нэгдсэн эмнэлэг, Захирал	88880858	ts.olonbayar01@gmail.com
5	Р.Баянмөнх	Цэргийн төв эмнэлэг, Эмнэлзүйн орлогч дарга эрхэлсэн	88029098	bayanaa02220@gmail.com
6	Л.Мишигдорж	Гранд Хүний нөөцийн дарга мед,	98100003	l.mishgee@gmail.com
7	Эркегүл	УБТЗТөв Дарга эмнэлэг	99903325	erkegul.ubtz@gmail.com

IV. Төгсөгчдийн нэрс

№	Нэр	Төгссөн он	Ажлын газар, албан тушаал	Утас	Цахим хаяг
1	Ж. Айсауле	2016	БЗД-13-р хороо “Эрүүл есөх” ӨЭМТ-л их эмч	95525348	Asjanat347@gmail.com
2	Д.Баттөр	2016	“Орбита” нүдний эмнэлэгт их эмч	89048141	battur0426@gmail.com

3	Б.Золзаяа	2017	Увс аймгийн Баруун туруун суманд дотрын их эмч	99345140	zoloob589@gmail.com
4	М.Мандахнар	2017	АУ-ны хүрээлэн мэдрэл судлалын секторт мэргэжилтэн	99982223	mandakhnar.ims@mnums.edu.mn
5	Б.Тэнгэрболд	2017	Орхон аймаг "Баян-Өндөр" эмнэлэгт чих хамар хоолойн их эмч	99386430	btengerbold@gmail.com
6	Б.Оюунгэрэл	2018	Ховд аймгийн Булган сумын даатгалын их эмч	99210721	Ozetgerlee@gmail.com
7	Г.Бүжмаа	2020	ШКНТЭ-д эмнэлгийн дотрын нарийн мэргэжлийн сургалтад суралцаж байна.	88503366	Bujka0525@gmail.com
8	М.Сэнгэрэвдан	2020	Омбол ХХК-д эмч төлөөлөгч	99252212	el.vamos.madrid@gmail.com
9	Т.Наран-Од	2021	MCS Property LLC-д Эрүүл мэндийн ажилтан	94676967	naraa.anna@gmail.com
10	Н.Энхжинмаа	2021	Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын эмнэлэгт хүүхэд хариуцсан их эмч	88878303	n.enkhjinmaa0422@gmail.com

V.Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэнсанал
/албан бичгийг оруулах/



БМИУЗ-д

Анагаах Ухааны Академийн Түшиц Байгууллага

**“АЧ” АНАГААХ УХААНЫ
ИХ СУРГУУЛЬ**

Улаанбаатар хот, СХД, 38-р хороо,
Энхтайваны өргөн чөлөө-11, Улаанбаатар 18101
Утас: 77119933, Факс: (976) 70172358
E-mail: info@ach.edu.mn, web: www.ach.edu.mn

2022-06-24 № 44

Санал хүргүүлэх нь

“Ач” АУИС-ийн сургалт эрхлэх 980122 тоот тусгай зөвшөөрлийн дагуу бакалавр зэрэгтэй “Хүний их эмч” мэргэжилтэн бэлтгэх 6 жилийн, D091201 индекстэй “Анагаах ухаан” сургалтын хөтөлбөрт БМИУЗ-өөс томилсон шинжээчдээр хөндлөнгийн үнэлгээ хийлгэж, хэлэлцүүлэн хөтөлбөрийг магадлан итгэмжлүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Уг ажлын хүрээнд зохих дүрэм журмын дагуу магадлан итгэмжлүүлэх өөрийн үнэлгээний тайлан бэлтгэн хүргэж, хөндлөнгийн шинжээчдэд тэдгээрийн илрэл нотолгоог газар дээр нь үзүүлэн танилцуулав.

БМИУЗ-ийн шинжээчийн тайлантай танилцаж санал бүрэн нийлж байна.

ЗАХИРАЛ



Н.БААСАНЖАВ